



БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ОЗОНЫ ДАВХАРГЫГ ХАМГААЛАХ ТАЛААР МОНГОЛ УЛСАД ДАГАЖ МӨРДӨХ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ЭМХЭТГЭЛ



Улаанбаатар хот
2020 он



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



БОАЖА-НЫ
ОЗОНЫ ҮНДЭСНИЙ АЛБА



НҮБ-ЫН БАЙГАЛЬ
ОРЧНЫ ХӨТӨЛБӨР

ОЗОНЫ ДАВХАРГЫГ ХАМГААЛАХ ТАЛААР МОНГОЛ УЛСАД ДАГАЖ МӨРДӨХ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ЭМХЭТГЭЛ

Озон задалдаг бодис болон орлуулах бодис,
тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүн, тоног
төхөөрөмжид тавих гаалийн болон хууль
хэрэгжүүлэх байгууллагаас тавих хяналт, хууль бус
худалдаанаас урьдчилан сэргийлэхэд зориулав.

УЛААНБААТАР ХОТ
2020 он



Multilateral Fund
for the Implementation of the Montreal Protocol

Энэхүү гарын авлагыг Олон талт сангийн санхүүжилтээр “Монгол Улсад гидрохлортфторт нүүрстөрөгч (ГХФН/НСFC) төрлийн хөргөх бодисыг үе шаттай бууруулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хэвлүүлэв.

Эмхэтгэсэн: Байгаль орчин, аялал жуулчлалын яамны
ОЗОНЫ ҮНДЭСНИЙ АЛБА
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ
Монгол Улс, Улаанбаатар хот 15160,
Чингэлтэй дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө,
IV байр, (Экспресс цамхаг)



**MINISTRY OF ENVIRONMENT
AND TOURISM**



**NATIONAL OZONE
AUTHORITY**



**UNITED NATIONS
ENVIRONMENT PROGRAMME**

LEGAL COMPILATION ON THE PROTECTION OF THE OZONE LAYER IN MONGOLIA

**Intended for customs and enforcement officers to
control and prevent illegal trade of ozone depleting
and other alternative substances and product &
equipment containing them**

**ULAANBAATAR
2020**



The handbook was published by the funding support from Multilateral Fund under the implementation framework of “HCFC Phase-out Management Plan for Mongolia”.

Compiled by: NATIONAL OZONE AUTHORITY
PROJECT MANAGEMENT UNIT OF
HPMP FOR MONGOLIA
Ministry of Environment and Tourism
Express Tower, Peace Avenue,
Chingeltei district, Ulaanbaatar 15160,
Mongolia

АГУУЛГА

Монгол улсын үндсэн хууль, 1992.....	11
Конвенцид нэгдэн орох тухай.....	12
Конвенцид оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орсныг соёрхон батлах тухай, 1995.....	13
Байгаль орчныг хамгаалах тухай, 1995.....	14
Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, 2001.....	16
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, 2006.....	18
Химийн хорт болон аюултай бодисын тухай, 2006.....	19
Гаалийн тухай, 2008.....	24
Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, 2010.....	28
Агаарын тухай, 2012.....	31
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, 2012.....	34
Эрүүгийн хууль, 2015.....	35
Зөрчлийн тухай, 2017.....	36
Хог хаягдлын тухай, 2017.....	39
Озоны үе давхаргыг хамгаалах тухай венийн конвенцоос.....	42
Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай монреалийн протоколоос.....	44
Төрөөс экологийн талаар баримтлах бодлого, 1997.....	50
Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого, 2019.....	51
Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 129 дүгээр тогтоол (<i>Үндэсний хөтөлбөр батлах тухай</i>).....	53
Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 54 дүгээр тогтоол (<i>Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон лицензтэй нэвтрүүлэх барааны кодлосон жагсаалт, журам батлах тухай</i>).....	63
Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 296 дугаар тогтоол (<i>Химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх боомтын жагсаалт батлах тухай</i>).....	67

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 95 дугаар тогтоол (<i>Журам, жагсаалт батлах тухай</i>).....	68
Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоол (<i>Улсын тэмдэгийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох тухай</i>).....	73
Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 303 дугаар тогтоол (<i>Жагсаалт батлах тухай</i>).....	75
Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 290 дүгээр тогтоол (<i>Журам, шинэчлэн батлах тухай</i>).....	77
Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоол (<i>Журам, жагсаалт батлах тухай</i>).....	79
Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 157 дугаар тогтоол (<i>Жагсаалт батлах тухай</i>).....	82
Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 277 дугаар тогтоол (<i>Журам, жагсаалт батлах тухай</i>).....	84
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 2009 оны 217/259 дугаар тушаал (<i>Хлортфторт нүүрстөрөгч агуулсан ингаляци хэлбэрийн эмийн бүртгэлийг зогсоох тухай</i>).....	128
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, гадаад харилцааны сайдын хамтарсан 2009 оны 334/104 дугаар тушаал (<i>Журам шинэчлэн батлах тухай</i>).....	129
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, гадаад харилцааны сайдын хамтарсан 2015 оны А356/396 дугаар тушаал (<i>Химийн хорт болон аюултай бодисын ангилал батлах тухай</i>).....	131
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/107 дугаар тушаал (<i>"Озоны үе давхаргыг хамгаалах тухай венийн конвенц", "Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн протокол"-ын нэгдсэн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай</i>).....	142
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 дугаар тушаал (<i>Жагсаалт батлах тухай</i>).....	145

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/450 дугаар тушаал (<i>Маягт шинэчлэн батлах тухай</i>).....	150
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/452 дугаар тушаал (<i>Эрх олгох тухай</i>).....	154
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, сангийн сайдын хамтарсан 2018 оны А429/257 дугаар тушаал (<i>Жагсаалт батлах тухай</i>).....	155
Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 67 дугаар тушаал (<i>Төлөвлөгөө батлах тухай</i>).....	157
Гаалийн ерөнхий газрын даргын 2008 оны 660 дугаар тушаал (<i>Журам батлах тухай</i>).....	159
Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны А/300 дугаар тушаал (<i>Жагсаалт шинэчлэн батлах тухай</i>).....	161
Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/212 дугаар тушаал (<i>Үндэсний кодод нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</i>).....	166
Озон задалдаг бодис болон орлуулах бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжтэй холбоотой зарим стандартын жагсаалт	187
Тусгай зөвшөөрлийн загвар.....	189

CONTENTS

The Constitution of Mongolia, 1992.....	11
The Accession to the Convention.....	12
The Ratification of the Accession to the Convention, 1995.....	13
Law on Environmental Protection, 1995.....	14
Law on Special Permission for Economic Entity's Business Activities, 2001.....	16
Law on Corporate Income Tax, 2006.....	18
Law on Toxic and Hazardous Chemicals, 2006.....	19
The Customs Law, 2008.....	24
Law on State Stamp Duty, 2010.....	28
Law on Air, 2012.....	31
Law on Environmental Impact Assessment, 2012.....	34
The Criminal Law, 2015.....	35
Law on Offences,2017.....	36
Law on Waste, 2017.....	39
The Vienna Convention for the Protection of the Ozone Layer.....	42
The Montreal Protocol on Substances that Deplete the Ozone.....	44
The State Ecological Policy,1997.....	50
The State Policy on Constuction, 2019.....	51
Government Resolution No.129 of 1999 <i>(The National Programme for the Protection of the Ozone Layer)</i>	53
Government Resolution No.54 of 2001 <i>(The Coded list of Goods Prohibited from Crossing the National Border of Mongolia)</i>	63
Government Resolution No.296 of 2006 <i>(The List of Border Entrance Ports that Allows Chemical and Hazardous Substance from Crossing the National Border of Mongolia)</i>	67
Government Resolution No.95 of 2007 <i>(The List of Toxic and Hazardous Chemicals Prohibited and Restricted to be Used in Mongolia)</i>	68

Government Resolution No.199 of 2011 (<i>The Schedule and Amount of Stamp Duty Fees</i>).....	73
Government Resolution No.303 of 2013 (<i>The Income Tax Exemption</i>).....	75
Government Resolution No.290 of 2017 (<i>The Regulation on Encouraging Citizens, Business Entities and Organizations that Have Introduced Environmentally Friendly and Advanced Technique and Technology</i>).....	77
Government Resolution No.116 of 2018 (<i>The Regulation on Storing, Collecting, Transporting, Recycling, Disposing, Registering and Reporting Hazardous Waste and the List of Hazardous Waste</i>).....	79
Government Resolution No.157 of 2018 (<i>The List of Air Purifying and Energy Efficient Heating Equipment</i>).....	82
Government Resolution No.277 of 2018 (<i>The Regulation for Licensing the Import, Sale and Use of ODSs and Other Substitutes and Equipment Containing Them and the Lists of ODSs, Other Alternative Substances and Equipment</i>).....	84
The Minister of Environment and Tourism and the Minister of Health' Joint Decree No.217/259 of 2009 (<i>The Termination of Drugs in the Form of Inhalation that Contain Chlorofluorocarbon</i>)	128
The Minister of Environment and Tourism and the Minister of Foreign Affairs' Joint Decree No.334/104 of 2009 (<i>The Regulation of Export, Import, Transportation, Production, Use and Sale of Toxic and Hazardous Chemicals</i>).....	129
The Minister of Environment and Tourism and the Minister of Foreign Affairs' Joint Decree No.A/356/396 of 2015 (<i>The Classification of Toxic and Hazardous Chemical Substance</i>).....	131
The Minister of Environment and Tourism Decree No.107 of 2016 (<i>The Composition of the National Committee on the “Vienna Convention for the Protection of the Ozone Layer” and the “Montreal Protocol on Substances that Deplete the Ozone Layer”</i>).....	142
The Minister of Environment and Tourism Decree No.A/349 of 2017 (<i>The List of Hazardous Wase</i>).....	145
The Minister of Environment and Tourism Decree No.A/450 of 2018 (<i>The</i>	

<i>Template for the Report of Imported, Sold and Used ODSs, and Other Alternative Substances and Equipment Containing Them)</i>	150
The Minister of Environment and Tourism Decree No.A/452 of 2018 (<i>The Signatories of the License for Import, Sale and Use of ODSs and Other Alternative Substances and Equipment Containing Them</i>).....	154
The Minister of Environment and Tourism and the Minister of Finances' Joint Decree No. A-429/257 of 2018 (<i>The List of Goods for Whose Generated Wastes a Manufacturer or Importer Shall be Responsible</i>).....	157
The Minister of Construction and Urban Development Decree No.67 of 2019 (<i>The Implementation Plan of the State Policy on Construction</i>).....	157
The Director of Customs General Administration Decree No.660 of 2008 (<i>The Regulation for the Sale of Seized Goods and Vehicles</i>).....	159
The Director of Customs General Administration Decree No.A/300 of 2017 (<i>The List of Goods Classified for Foreign Trade Based on the Harmonized System Code</i>).....	161
The Director of Customs General Administration Decree No.A/212 of 2019 (<i>The Amended List of National Codes</i>).....	166
The list of some standards relevant to ozone depleting and other alternative substances and product and equipment containing them.....	187
List of Special License.....	189

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

1992 оны 1 дүгээр
сарын 13- ны өдөр

Улаанбаатар хот

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

Арван зургадугаар зүйл

Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;

ГУРАВДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

Гучин наймдугаар зүйл

2. Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4/ хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах;

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 10 дугаар
сарын 16- ны өдөр

Улаанбаатар хот

КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. “Озоны үе давхаргыг хамгаалах тухай” Венийн 1985 оны конвенци, 1991 оны 6 дугаар сарын 27-29-нд Лондонд, 1991 оны 6 дугаар сарын 19-21-нд Найробид, 1992 оны 11 дүгээр сарын 23-25-нд Копенгагенд болсон талуудын зөвлөлгөөнөөр засвар, залруулга, нэмэлт, өөрчлөлт оруулсан “Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай” Монреалийн 1987 оны протоколд тус тус нэгдэн орсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 1 дүгээр
сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

КОНВЕНЦИД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨД НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай конвенцид Монреалийн Протоколын 9 дүгээр хуралдаанаас оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орсныг соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 3 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ЗУРГАДУГААР БҮЛЭГ

БАЙГАЛЬ ОРЧИН, БАЙГАЛИЙН БАЯЛГИЙГ ХАМГААЛАХ ТАЛААРХИ

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ

31 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

Аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараахь үүрэгтэй байна:

2/эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны холбогдолтой стандарт, хэм хэмжээ, дүрэм, журмыг чанд сахин биелүүлж, дотоодын хяналтыг хэрэгжүүлэх;

3/үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх явцад байгаль орчинд гаргаж байгаа хорт бодис, физикийн хортой нөлөөлөл, хог хаягдлын хэмжээг бүртгэж, тэдгээрийг багасгах, цэвэрлэх талаар авсан арга хэмжээ, хянах төхөөрөмжийн ажиллагааны тухай тайлан мэдээг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад өгөх;

4/байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах, зогсоох болон байгаль орчныг хамгаалах,

нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлэх;

7/бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд ялгаруулж байгаа хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй байх.

8/хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдийн байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хариуцлага хүлээлгэхийг Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагчаас шаардах;

9/өөрийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учруулсан хохирлыг арилгах, холбогдох байгууллагад мэдэгдэх, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн ногдуулсан нөхөн төлбөрийг ажлын 14 хоногт багтаан төлөх;

10/байгаль орчинд хохирол учруулж болох аливаа үйлдлээс татгалзах.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 2 дугаар
сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох журам

7.1. Энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны холбогдох төв байгууллага олгоно.¹

¹ БОАЖ-ын сайдын А/452 дугаар тоот тушаал

7.3. Тухайн төрлийн аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмыг тус тусын хуулиар зохицуулна.

15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл

15.6. Байгаль орчны чиглэлээр:

15.6.1. озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, худалдах, ашиглах;

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

18 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

18.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

ТАВДУГААР БҮЛЭГ

Албан татварын хувь, хэмжээ

18 дугаар зүйл. Албан татвараас чөлөөлөх

18.4. Байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд халгүй техник, тоног төхөөрөмжийн жагсаалтыг Засгийн газар батална.²

/Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

²

Засгийн газрын 303 дугаар тогтоол, 2013

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 5 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, Монгол Улсын хилээр дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хууль тогтоомж

2.1. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Байгаль орчныг хамгаалах тухай хууль², Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль³, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль⁴, Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хууль⁵, Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль⁶, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль⁷, Гамшгаас хамгаалах тухай хууль⁸, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

4 дүгээр зүйл. Химийн хорт болон аюултай бодисын ангилал

4.1. Химийн бодисыг шинж чанар болон хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд үзүүлэх нөлөөллөөр нь:

4.1.1. хортой;

4.1.2. аюултай гэж тус тус ангилна.

4.2. Химийн хорт болон аюултай бодисын ангиллыг байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

/Дээрх 4 дүгээр зүйлийг 2008 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Химийн хорт болон аюултай бодистой холбогдох үйл ажиллагааг зохицуулахад тавих үндсэн шаардлага

8 дугаар зүйл. Химийн хорт болон аюултай бодисоос хамгаалахад тавих үндсэн шаардлага

8.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хилээр дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах явцад хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, гарсан хор уршгийг арилгах арга хэмжээг өөрийн зардлаар авч хэрэгжүүлнэ.

8.2. Энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь

холбогдох хууль тогтоомж, аюулгүй ажиллагааны дүрэм, технологийн горимыг дагаж мөрдөнө.

9 дүгээр зүйл. Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хилээр дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэхэд тавих үндсэн шаардлага

9.1. Энэ хуулийн 5.1-д заасны дагуу химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, үйлдвэрлэх, ашиглах зөвшөөрөл авахдаа тухайн бодисын талаар дараахь мэдээллийг бүрдүүлнэ

- 9.1.1. бодисын нэр, томъёо;
- 9.1.2. худалдааны болон техникийн нэр;
- 9.1.3. олон улсын бүртгэлийн дугаар;
- 9.1.4. ашиглах газар, зориулалт, хугацаа, тоо хэмжээ;
- 9.1.5. физик, химийн болон хор аюулын шинж чанар;
- 9.1.6. болзошгүй осол, эрсдлийн үед авах арга хэмжээ;
- 9.1.7. үйл ажиллагаа явуулах ажлын байрны дүгнэлт;
- 9.1.8. тухайн бодис, түүний хольц, хаягдлыг устгах аргачлал, тээвэрлэх арга.

9.2. Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хилээр дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэхдээ энэ хуулийн 6.1.1-д заасны дагуу батлагдсан журмыг мөрдөнө.

11 дүгээр зүйл. Химийн хорт болон аюултай бодис худалдахад тавих үндсэн шаардлага

11.1. Тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хорт болон аюултай бодис худалдахдаа худалдан авсан этгээдийн хаяг, бодисын нэр, төрөл, хэмжээ, ашиглах зориулалтыг заасан баримтыг 2 хувь үйлдэн баталгаажуулж, нэг хувийг худалдан авагчид, үлдсэн хувийг өөртөө хадгална.

13 дугаар зүйл. Химийн хортболон аюултай бодис ашиглахад тавих үндсэн шаардлага

13.1. Химийн хорт болон аюултай бодис ашиглахтай холбоотой үйл ажиллагааг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбайд явуулна.

13.2. Химийн хорт болон аюултай бодис ашиглах явцад тухайн ажлын байр болон байгаль орчинд эрх бүхий байгууллагаас тогтоосон химийн хорт болон аюултай бодисын хүлцэх хэмжээг хэтрүүлэхийг хориглоно.

15 дугаар зүйл. Химийн хортболон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх

15.4. Зохих зөвшөөрөлгүйгээр химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

17 дугаар зүйл. Эрсдлийн үнэлгээ

17.1. Химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх, хадгалах, ашиглах үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн бодисын

эрсдлийн үнэлгээг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу заавал хийлгэнэ.

17.2. Эрсдлийн үнэлгээнд тухайн химийн хорт болон аюултай бодисын хор, аюулын шинж чанар, болзошгүй эрсдлийг судлан тодорхойлох, түүнээс сэргийлэх арга хэмжээ болон хаягдлыг хоргүйжүүлэн устгах асуудлыг тусгана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

19 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

19.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

19.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

20 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлүүлэх

20.1. Химийн хорт болон аюултай бодистой холбогдох хууль тогтоомж зөрчиж, хууль бус үйл ажиллагаа явуулсны улмаас бусдын эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтан, эд хөрөнгөд учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 5 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

ГААЛИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

I ХЭСЭГ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн хяналт хэрэгжүүлэх журам, гаалийн бүрдүүлэлтийн горим, нөхцөл, шаардлагыг тогтоох, гаалийн байгууллагын тогтолцоо, гаалийн байгууллага, албан тушаалтны эрх, үүргийг тодорхойлох, тэдгээрийн шийдвэрт иргэнээс гомдол гаргах, түүнийг гаалийн байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэх, гаалийн хууль тогтоомжийг зөрчигчид хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

/Энэ хэсгийг 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.14. “тарифын бус хязгаарлалт” гэж Монгол Улсын хилээр бараа нэвтрүүлэхийг хориглох, эсхүл эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, тоон хязгаарлалт тогтоох болон бусад арга хэмжээг;

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхэд баримтлах зарчим

8 дугаар зүйл. Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхийг хориглох, хязгаарлах

8.1. Хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурал улсын хилээр оруулах, гаргахыг хориглох барааны, Засгийн газар тарифын бус хязгаарлалттай нэвтрүүлэх барааны жагсаалтыг тухайн барааны ангиллын кодыг Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн дагуу зааж тус тус батална.

8.2. Улсын хилээр оруулахыг хориглосон барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулахгүй.

8.3. Энэ хуулийн 8.2-т заасан барааг Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулсан бол нэн даруй буцаан гаргах ба ийнхүү гаргах боломжгүй бол гаалийн хяналтын бүс, эсхүл түр агуулахад 3 хүртэл хоног хадгалах бөгөөд энэ хугацаанд иргэн, хуулийн этгээд бараагаа буцаан гаргаагүй бол гаалийн байгууллага бараа устгах горимын дагуу арга хэмжээг авна.

8.4. Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалттай барааг хууль тогтоомж, олон улсын гэрээнд заасан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн хилээр нэвтрүүлнэ.

8.6. Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааг гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхгүй.

8.8. Энэ хуулийн 8.3-т заасан үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг тухайн иргэн, хуулийн этгээд хариуцна.

8.9. Гаалийн хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааг хууль бусаар нэвтрүүлсэн, эсхүл нэвтрүүлэхийг завдсан үйлдэл нь энэ хуулийн 8.3-т хамаарахгүй.

II ХЭСЭГ ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ

ЗУРГАДУГААР БҮЛЭГ Гаалийн бүрдүүлэлт хийх

Нэгдүгээр дэд бүлэг Нийтлэг үндэслэл

29 дүгээр зүйл. Гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлт

29.1. Гаалийн хилээр нэвтрүүлэх дор дурдсан бараанд гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлтийг хийж болно:

29.1.2. цацраг идэвхт бодис, химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис;

29.2. Энэ хуулийн 29.1-д заасан бараанд гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтыг гаалийн байгууллагаас тогтоосон хугацаанд бүрдүүлж өгөх болзолтойгоор дараалал харгалзахгүй гаалийн бүрдүүлэлт хийнэ.

29.3. Энэ хуулийн 29.1-д заасан барааг мэдүүлэгч нь гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтыг гаалийн байгууллагаас тогтоосон хугацаанд гаргаж өгөх баталгааг бичгээр гаргана.

Зургадугаар дэд бүлэг

Бараа мэдүүлэх

60 дугаар зүйл. Бараа мэдүүлэхэд шаардагдах бусад бичиг баримт

60.3. Мэдүүлэгч гаалийн мэдүүлэгт өгсөн мэдээллийнхээ үнэн зөвийг нотлох зорилгоор дараах бичиг баримтыг гаалийн байгууллагад өгнө:

60.3.1. гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэх;

60.3.2. тээврийн бичиг баримт;

60.3.3. тарифын бус хязгаарлалтад хамаарах бараанд шаардагдах зөвшөөрөл, лиценз;

60.3.4. хууль тогтоомжид тусгайлан заасан бараанд мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон дүгнэлт;

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 11 дүгээр
сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

3 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамж

3.1. Төрийн эрх бүхий байгууллагаас энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлсний төлөө иргэн, хуулийн этгээдийн төлж байгаа мөнгөн хөрөнгийг улсын тэмдэгтийн хураамж /цаашид “тэмдэгтийн хураамж” гэх/ гэнэ.

5 дугаар зүйл. Тэмдэгтийн хураамж хураах үйлчилгээний төрөл

5.1. Тэмдэгтийн хураамжийг дор дурдсан үйлчилгээнд хураана:

5.1.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох;

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

21 дүгээр зүйл. Байгаль орчны чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

21.1. Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан

21.1.9. озон задалдаг бодисыг системээс юүлэх, цэвэрлэх, дахин цэнэглэх, засвар үйлчилгээ хийх, устгах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 40 000-100 000 төгрөг;

21.1.10. озоны давхаргыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, байгаль орчинд ээлтэй бодис импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл олгоход 11 000-27 000 төгрөг;

21.1.11. озон задалдаг бодисын хольц агуулсан дараах тоног төхөөрөмж импортлох, худалдах зөвшөөрөл олгоход:

а. гэр ахуйн хөргөгч, хөлдөөгч 10000-25 000 төгрөг;

б. иргэн, олон нийтийн барилга, орон сууцны агааржуулагч, хөргөх хэрэгсэл 20 000-50 000 төгрөг;

в. үйлдвэр болон томоохон зочид буудлын хөргөх систем 40000-100 000 төгрөг;

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

46 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

46.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

46.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 5 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

АГААРЫН ТУХАЙ **/Шинэчилсэн найруулга/**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.20. “озоны үе давхарга” гэж дэлхийн гадаргаас дээш орших хийн мандлын озоны давхаргыг;

3.1.21. “хүлэмжийн хий” гэж хэт улаан туяаг шингээн авч буцаан туяаруулах шинж чанартай байгалийн буюу хүний үйл ажиллагааны гаралтай хийн мандлын бүрэлдэхүүн хэсгийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

АГААР ХАМГААЛАХ ТАЛААРХ ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ИРГЭНИЙ НИЙТЛЭГ ЭРХ, ҮҮРЭГ

7 дугаар зүйл. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

7.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага/цаашид “төрийн захиргааны

төв байгууллага” гэх/ агаар хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.7. озон задалдаг бодис болон бусад орлуулах бодисын хэрэглээг үе шаттайгаар бууруулах, хязгаар тогтооход хяналт тавих;

11 дүгээр зүйл. Агаарын чанарын хяналт-шинжилгээ

11.1. Төрийн захиргааны төв байгууллага нь агаарын чанар, агаарт үзүүлэх физикийн сөрөг нөлөөлөл, хүчиллэг тунадас, давхраат мандлын озон, хүлэмжийн хийн агууламжийн өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа, шинжилгээ хийж үнэлгээ өгөх, мэдээллээр хангах зорилго бүхий хяналт-шинжилгээний улсын нэгдсэн сүлжээг зохион байгуулж ажиллуулна.

25 дугаар зүйл. Озоны үе давхаргыг хамгаалах

25.1. Озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн жагсаалт болон тэдгээрийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар батална.

25.2. Тухайн жилд импортлох озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн тоо хэмжээг төрийн захиргааны төв байгууллага жил бүр тогтоож, эдгээр бодис, тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл олгоно.

25.3. Энэ хуулийн 25.1-д заасан жагсаалтад орсон бодис, тоног төхөөрөмжийн импорт, худалдаа, үйлдвэрлэлийн тухай мэдээллийг гаалийн байгууллага болон үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэн энэ хуулийн 12.5-д заасан журмын дагуу мэргэжлийн албанд гаргаж өгнө.

25.4. Озон задалдаг бодис болон бусад орлуулах бодисыг юүлэх, дахин боловсруулах, тоног төхөөрөмжийг дахин цэнэглэх үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

25.5. Озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмж болон хураагдсан бодисыг устгах, зайлуулах, нөөцөлж хадгалах асуудлыг холбогдох хуулиар зохицуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

31 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

31.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

31.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 5 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

ХОЁРДУГААР БҮЛЭГ

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ БҮТЭЦ, ТОГТОЛЦОО, ЗОХИЦУУЛАЛТ

7 дугаар зүйл. Нөлөөллийн үнэлгээ

7.1. Нөлөөллийн үнэлгээ нь дараах үнэлгээнээс бүрдэнэ:

7.1.1. байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ;

7.1.2. байгаль орчны нөлөөллийн
нарийвчилсан үнэлгээ.

7.4. Шинээр байгуулах болон одоо ажиллаж байгаа үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх, байгалийн нөөц ашиглах төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг үнэлгээний шинжээч ажлын 14 хоногт багтаан хийж дараах дүгнэлт гаргана:

7.4.1. техник, технологи, үйл ажиллагаа нь байгаль орчинд халтай, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, стратегийн үнэлгээний дүгнэлт болон холбогдох хууль тогтоомжид нийцээгүй төслийг хэрэгжүүлэхээс татгалзах, эсхүл буцаах;

7.4.2. төслийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэлгүйгээр тодорхой нөхцөл, болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой гэж үзэх;

7.4.3. байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэх.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/

ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

24.1 дүгээр зүйл. Байгаль орчныг бохирдуулах

1.Химийн хорт, аюултай бодис, аюултай, хортой хог хаягдлыг агаар, газар, газрын хэвлий, усны сан бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, эх үүсвэрийн тэжээгдлийн муж, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс дотор хаяж хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

24.3 дугаар зүйл. Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах

1.Химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлсэн, үйлдвэрлэсэн, хадгалсан, худалдсан, авсан, тээвэрлэсэн, бусдад дамжуулсан, зориулалтын бусаар ашигласан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 5 дугаар
сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ **/Шинэчилсэн найруулга/**

ЕРӨНХИЙ АНГИ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ **НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 дүгээр зүйл. Хуулийн зорилго

1.Энэ хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино.

ТАВДУГААР БҮЛЭГ **НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН** **ЭСРЭГ ЗӨРЧИЛ**

5.11 дүгээр зүйл. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зөрчих

1. Химийн хорт, аюултай бодис:
 - 1.1. экспортлох;
 - 1.2. импортлох;
 - 1.3. хилээр дамжуулан тээвэрлэх;
 - 1.4. үйлдвэрлэх;

1.5. тээвэрлэх;

1.6. хадгалах;

1.7. худалдах;

1.8. ашиглах;

1.9. устгах үндсэн шаардлага, журам, аюулгүй ажиллагааны дүрэм, технологийн горимыг зөрчсөн бол зөрчлийг арилгуулж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Хуульд заасны дагуу батлагдсан химийн хорт, аюултай бодистой холбогдох үйл ажиллагааг зохицуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаархи журам зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Химийн хорт, аюултай бодистой холбогдсон үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Химийн хорт, аюултай бодисын хүний эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн хүлцэх хэмжээний талаархи стандартыг зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6. Химийн хорт болон аюултай бодисын ашиглалт, зарцуулалтад дотоод хяналт тавиагүй бол хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

БАЙГАЛЬ ОРЧИН, АМЬТАН, УРГАМЛЫГ ХАМГААЛАХ ЖУРМЫН ЭСРЭГ ЗӨРЧИЛ

7.4 дүгээр зүйл. Агаарын тухай хууль зөрчих

1. Агаарын чанарт сөргөөр нөлөөлж байгаа өөрийн үйл ажиллагааны тухай мэдээлэл, озон задалдаг бодис, түүнийг орлуулах бусад бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн импорт, үйлдвэрлэлийн тухай мэдээлэл, агаарын бохирдлын эх үүсвэрийн тухай мэдээлэл, агаарт гаргасан бохирдуулах бодисын агууламж, хаягдлын хэмжээ, дотоод хяналтын мэдээг:

1.1. тогтоосон хугацаанд мэдээлэлгүй;

1.2. зориуд буруу мэдээлсэн;

1.3. нуун дарагдуулсан, эсхүл хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 5 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаархи боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

4.1.2. “аюултай хог хаягдал” гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг;

4.1.38. “аюултай хог хаягдал үүсгэгч” гэж үйл ажиллагаа болон үйлдвэрлэлээс нь аюултай хог хаягдал үүсдэг аж ахуйн нэгж, байгууллагыг;

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ, ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

8 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

8.1. Хог хаягдлын талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.6. эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэлийг батлах;³

8.1.14. үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалтыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах.⁴

ТАВДУГААР БҮЛЭГ

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ САВЛАХ, ТҮР ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ЦУГЛУУЛАХ, ХАДГАЛАХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ

24 дүгээр зүйл. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх

24.1. Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын олгосон зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага эрхэлнэ.

³ БОАЖ-ын сайдын А/349 дугаар тушаал, 2017

⁴ БОАЖ-ын сайдын А429/257 дугаар тушаал, 2018

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

43 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

43.1. Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол улсын байцаагч, цагдаа болон сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга дараахь хариуцлага хүлээлгэнэ:

43.1.1. энэ хуулийн 7.1.2-т заасан журмыг зөрчсөн бол хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сая төгрөгөөр торгох;

ОЗОНЫ ҮЕ ДАВХАРГЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ВЕНИЙН КОНВЕНЦООС

“Озоны үе давхаргыг хамгаалах тухай” Венийн Конвенцийг 1985 онд Вена хотноо хуралдсан дипломат Бага хурлаар баталсан. Уг конвенци нь 1996 оны 6 дугаар сарын 5-нд **Монгол улсад** хүчин төгөлдөр болж, олон улсын байгууллага, улс орнуудтай энэ салбарт хамтран ажиллах өргөн боломж нээгдсэн юм.

Уг конвенцид озоны давхаргад нөлөөлдөг бодисуудын ялгаралтыг бууруулахад чиглэсэн бодлого, стратеги, арга хэмжээг зохицуулан зохион байгуулж хэрэгжүүлэх талаар нэгдэн орсон Талууд тодорхой үүрэг хүлээнэ гэдгийг заасан.

Агаар мандалд 20-25 км-ийн хоорондох хамгийн их нягтралтай озоны давхарга нь дэлхий дээрхи амьд бие махбодыг нарны хит ягаан туяанаас хамгаалдаг. Хэт ягаан туяаны хэмжээ газрын гадаргууд хичнээн их нэвтэрч орж ирнэ, тэр хэмжээгээр арьсны төрөл бүрийн хорт хавдар, нүдний өвчин зэрэг олон янзын өвчин нэмэгдэж, ургамлын хэмжээ буурна гэж эрдэмтэд тооцоолжээ.

Иймд озоны давхаргад учрах хөнөөлийг нэмэгдүүлэхгүй байхын тулд юуны өмнө хлорт фтортнүүрс устөрөгчид, гидрохлорфтор нүүрстөрөгч, галогений төрлийн бодисыг үйлдвэрлэх, импорт, хэрэглээг зогсоож, тэдгээрийг өөр бодисоор орлуулах шаардлага бүх улс түмний өмнө тавигдаж байна.

Монгол улсын засгийн газрын 1999 оны 129 дүгээр тогтоолоор Озоны үндэсний хороо байгуулж, “Озоны үе давхаргыг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг баталсан

бөгөөд 2018 онд “Озон задалдаг болон орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох журам”-ыг шинэчлэн батлаад байна.

Мөн 2017 онд “**MNS EN 13313:2017** Хөргөлтийн систем болон дулааны насос – Ажилтны ур чадвар” стандартыг үндэсний хэмжээнд хэрэглэхээр хүлээн зөвшөөрч үндэсний стандартаар батлуулаад байна.

ОЗОНЫ ҮЕ ДАВХАРГЫГ ЗАДАЛДАГ БОДИСЫН ТУХАЙ МОНРЕАЛИЙН ПРОТОКОЛООС

“Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай” Монреалийн протоколыг 1987 онд Монреаль хотноо хуралдсан Протоколын Талуудын Бага хурлаас баталсан байна.

Одоогийн байдлаар Монреалийн протоколд 198 Тал-Улс орон нэгдэн орж, Олон Талт санг үүсгэн санаачилсан байна. Олон талт сангаас хөгжиж байгаа орнууд хөрөнгө, санхүүгийн тусламж авч, озон задалдаг бодисын жагсаалт гаргах, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, техник, технологийн тооллого явуулах, тэдгээр бодисыг орлуулах боломж, техник, технологи нэвтрүүлэх талаар судалгаа хийдэг.

Озон задалдаг бодисыг орлуулахаар хэрэглээнд нэвтрүүлсэн **гидрофторт нүүрстөрөгч** (ГФН/НFC) төрлийн химийн бодисууд озон задалдаггүй ч дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар (ДДНЧ) өндөртэй учир Монреалийн протокол хүрээлэх орчныг хамгаалах зорилтоо дахин нэг шатаар ахиулж, 2016 онд Руанда улсын Кигали хотноо зохион байгуулсан Талуудын 28 дугаар бага хурлаар ГФН/НFC төрлийн бодисын үйлдвэрлэл, хэрэглээг үе шаттай бууруулах зорилготой нэмэлт, өөрчлөлтийг батламжилсан билээ. Энэхүү Кигалийн нэмэлт өөрчлөлт 2019 оны 01 сарын 01-нээс хүчин төгөлдөр болоод байна.

Протоколын зорилго нь түүний хяналтад орсон озон задалдаг бодис (ОЗБ) болон ОЗБ-ыг орлуулах гидрофторт нүүрстөрөгч (ГФН/НFC)-ийн төрлийн бодисын хэрэглээг бууруулан улмаар хэрэглээнээс гаргах асуудлыг зохицуулна.

2010 онд хлорт фтортнүүрс нүүрстөрөгч (ХФН/CF₂) хөргөх бодисыг бүр мөсөн хэрэглээнээс гаргасан бол, 2030 он гэхэд гидрохлорфторт нүүрстөрөгч (ГХФН/HCFC) төрлийн хөргөх бодисыг хэрэглээнээс гаргах, дэлхийн дулааралд нөлөөтэй хүлэмжийн хий болох гидрофторт нүүрстөрөгч (ГФН/НFC)-ийн төрлийн хөргөх бодисыг 2045 он гэхэд 85 хувь бууруулах үүрэг хүлээж байна.

МОНРЕАЛИЙН ПРОТОКОЛЫН ХАВСРАЛТУУД

ЗОХИЦУУЛАХ БОДИС

Хавсралт А

Бүлэг	Бодис	Озон задлах чадвар	Дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар
I бүлэг			
CFCl ₃	(ХФН-11)	1.0	4 750
CF ₂ Cl ₂	(ХФН-12)	1.0	10 900
C ₂ F ₃ Cl ₃	(ХФН-113)	0.8	6 130
C ₂ F ₄ Cl ₂	(ХФН-114)	1.0	10 000
C ₂ F ₅ Cl	(ХФН-115)	0.6	7 370
II бүлэг			
CF ₂ BrCl	(Галон-1211)	3.0	
CF ₃ Br	(Галон-1301)	10.0	
C ₂ F ₃ Br ₃	(Галон -2402)	6.0	

ЗОХИЦУУЛАХ БОДИС

Бүлэг	Бодис	Озон задлах чадвар
I бүлэг		
CF_3Cl	(ХФН-13)	1.0
C_2FCl_5	(ХФН-111)	1.0
$C_2F_2Cl_4$	(ХФН-112)	1.0
C_3FCl_7	(ХФН-211)	1.0
$C_3F_2Cl_6$	(ХФН-212)	1.0
$C_3F_3Cl_5$	(ХФН-213)	1.0
$C_3F_4Cl_4$	(ХФН-214)	1.0
$C_3F_5Cl_3$	(ХФН-215)	1.0
$C_3F_6Cl_2$	(ХФН-216)	1.0
C_3F_7Cl	(ХФН-217)	1.0
II бүлэг		
CCl_4	Дөрвөн хлорт метан	1.1
III бүлэг		
$C_2H_3Cl_3$	Гурван хлорт этан (метил блороцорм)	0.1

ЗОХИЦУУЛАХ БОДИС

Бүлэг	Бодис	Изомерийн тоо	Озон задлах чадвар	Дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар	
I бүлэг					
	CHFCI ₂	(ГХФН-21)**	1	0.04	151
	CHF ₂ Cl	(ГХФН-22)**	1	0.055	1 810
	CH ₂ FCI	(ГХФН-31)	1	0.02	
	C ₂ HFCl ₄	(ГХФН-121)	2	0.01-0.04	
	C ₂ HF ₂ Cl ₃	(ГХФН-122)	3	0.02-0.08	
	C ₂ HF ₃ Cl ₂	(ГХФН-123)	3	0.02-0.06	77
	CHCl ₂ CF ₃	(ГХФН-123)**		0.02	
	C ₂ HF ₄ Cl	(ГХФН-124)	2	0.02-0.04	609
	CHFClCF ₃	(ГХФН-124)**		0.022	
	C ₂ H ₂ FCI ₃	(ГХФН-131)	3	0.007-0.05	
	C ₂ H ₂ F ₂ Cl ₂	(ГХФН-132)	4	0.008-0.05	
	C ₂ H ₂ F ₃ Cl	(ГХФН-133)	3	0.02-0.06	
	C ₂ H ₂ FCI ₂	(ГХФН-141)	3	0.005-0.07	
	CH ₂ CFCl ₂	(ГХФН-141b)**		0.11	725
	C ₂ H ₃ F ₂ Cl	(ГХФН-142)	3	0.008-0.07	
	CH ₂ Cl ₂ Cl	(ГХФН-142b)		0.065	2310
	C ₂ H ₄ FCI	(ГХФН-151)	2	0.003-0.005	
	C ₃ HFCl ₆	(ГХФН-221)	5	0.015-0.07	
	C ₃ HF ₂ Cl ₅	(ГХФН-222)	9	0.01-0.09	
	C ₃ HF ₃ Cl ₄	(ГХФН-223)	12	0.01-0.08	
	C ₃ HF ₄ Cl ₃	(ГХФН-224)	12	0.01-0.09	
	C ₃ HF ₅ Cl ₂	(ГХФН-225)	9	0.02-0.07	
	CF ₃ CF ₂ CHCl ₂	(ГХФН-225ca)**		0.025	122
	CF ₂ ClCF ₂ CHCl ₂ F	(ГХФН-225cb)**		0.033	595
	C ₃ HF ₆ Cl	(ГХФН-226)	5	0.02-0.10	
	C ₃ H ₂ FCI ₅	(ГХФН-231)	9	0.05-0.09	
	C ₃ H ₂ F ₂ Cl ₄	(ГХФН-232)	16	0.008-0.10	
	C ₃ H ₂ F ₃ Cl ₃	(ГХФН-233)	18	0.007-0.23	
	C ₃ H ₂ F ₄ Cl ₂	(ГХФН-234)	16	0.01-0.28	
	C ₃ H ₂ F ₅ Cl	(ГХФН-235)	9	0.03-0.52	
	C ₃ H ₃ FCI	(ГХФН-241)	12	0.004-0.09	
	C ₃ H ₃ F ₂ Cl ₃	(ГХФН-242)	18	0.005-0.13	
	C ₃ H ₂ F ₃ Cl ₂	(ГХФН-243)	18	0.007-0.12	
	C ₃ H ₂ F ₄ Cl	(ГХФН-244)	12	0.009-0.14	
	C ₃ H ₄ FCI ₃	(ГХФН-251)	12	0.001-0.01	
	C ₃ H ₄ F ₂ Cl ₂	(ГХФН-252)	16	0.005-0.04	
	C ₃ H ₄ F ₃ Cl	(ГХФН-253)	12	0.003-0.03	
	C ₃ H ₅ FCI ₂	(ГХФН-261)	9	0.002-0.02	
	C ₃ H ₅ F ₂ Cl	(ГХФН-262)	9	0.002-0.02	
	C ₃ H ₆ FCI	(ГХФН-271)	5	0.001-0.03	

Хавсралт D

А ХАВСРАЛТАД ОРСОН ЗОХИЦУУЛАГДАХ БОДИС АГУУЛЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖАГСААЛТ

Бүтээгдэхүүн	Гаалийн кодын товъёог
1. Ачааны болон суудлын автомашины агааржуулагч төхөөрөмж (автомашинд суурьлуулсан, суурилуулаагүй эсэхээс хамаарахгүй)	
2. Ахуйн зориулалттай, ахуйн зориулалтаас бусад худалдаа, нийтийн хоолны зориулалттай хөргөгч, хөргөх төхөөрөмж болон агааржуулагч төхөөрөмж /дулааны насос Жишээ нь: <ul style="list-style-type: none"> – Хөргөгч – Хөлдөөгч – Агаар хатаагч/ууршуулагч – Усан хөргөлтийн төхөөрөмж – Мөсний машин – Агааржуулагч төхөөрөмж, дулааны насос 	
3. Эмнэлэг, лабораторийн зориулалттай аэрозолоос бусад аэрозоль бүтээгдэхүүн	
4. Зөөврийн гал унтраагуур	
5. Дулаалгын тавцан, хавтан, хоолойн тусгаарлагч	
6. Пре-полимер	

ЗОХИЦУУЛАХ БОДИС

Бүлэг	Бодис	Дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар
I бүлэг		
CHF_2CHF_2	(ГФН-134)	1 100
CH_2FCF_3	(ГФН-134a)	1 430
CH_2FCHF_2	(ГФН-143)	353
$\text{CHF}_2\text{CH}_2\text{CF}_3$	(ГФН-245fa)	1 030
$\text{CF}_3\text{CH}_2\text{CF}_2\text{CH}_3$	(ГФН-365mfc)	794
$\text{CF}_3\text{CHF}_2\text{CF}_3$	(ГФН-227ea)	3 220
$\text{CH}_2\text{FCF}_2\text{CF}_3$	(ГФН-236cb)	1 340
$\text{CHF}_2\text{CHF}_2\text{CF}_3$	(ГФН-236ea)	1 370
$\text{CF}_3\text{CH}_2\text{CF}_3$	(ГФН-236fa)	9 810
$\text{CH}_2\text{FCF}_2\text{CHF}_2$	(ГФН-245ca)	693
$\text{CF}_3\text{CHFCH}_2\text{CF}_2\text{CF}_3$	(ГФН-43-10mee)	1 640
CH_2F_2	(ГФН-32)	675
CHF_2CF_3	(ГФН-125)	3 500
CH_3CF_3	(ГФН-143a)	4 470
CH_3F	(ГФН-41)	92
$\text{CH}_2\text{FCH}_2\text{F}$	(ГФН-152)	53
CH_3CHF_2	(ГФН-152a)	124
II бүлэг		
CHF_3	(ГФН-23)	14 800

Улсын Их Хурлын 1997 оны 106 дугаар
тогтоолын хавсралт

ТӨРӨӨС ЭКОЛОГИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

III. Байгаль орчны бодлогын үндсэн чиглэл

3.11.7. амьдрах орчны даац, чадавхийг уур амьсгалын хувьсал өөрчлөлтийн болон байгалийн гамшгийн аюулын болзошгүй үр дагавартай холбон тандан судалж, бүрэн арилгах боломжгүй бохирдлын хэмжээг экологийн тэнцэлд нийцүүлэн агаар, ус, хөрсний орчинд зохистой байрлуулах, хүлэмжийн хийг ихээр ялгаруулж, озоны давхаргыг задалдаг бодисын үйлдвэрлэл, хэрэглээ, туршилтыг хязгаарлах, унах хур тундас, усан сангийн хуримтлалын хэмжээг нэмэгдүүлж газар дэлхийгээ цэцэрлэгжүүлэх, газрын

IV. Эдийн засаг, нийгмийн бодлого, зохицуулалт

4.3.14. дэлхийн хамтын нийгэмлэгийн дэмжлэг, улс хоорондын хамтын ажиллагааны боломжид түшиглэн дэлхийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ, олон улсын байгаль хамгаалах конвенцид нэгдэн орж эдийн засаг, гадаад худалдааг тэдгээрийн зарчимд нийцүүлэн зохистой хөгжүүлнэ. Озоны хомсдол, уур амьсгалын таагүй өөрчлөлтийн нөлөөг сааруулах, амьдрах орчинд аюултай хог хаягдал гадаадаас оруулж хадгалах, булшлахыг хориглох, хил дамжин нэвтэрч болзошгүй цацраг идэвхжил, агаар, усны бохирдлын хөнөөлөөс урьдчилан сэргийлэх чадавхийг бэхжүүлэх, байгалийн гамшиг, нөөц баялгийн хомсдлын уршгийг үнэлж мэдээлэх, хянан сэргийлэх бүс нутгийн тогтолцоог бүрдүүлэх замаар экологийн аюулгүй байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлнэ;

ТӨРӨӨС БАРИЛГЫН САЛБАРЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Бодлого боловсруулах нийтлэг үндэслэл:

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенци, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Ногоон хөгжлийн бодлого”-д тусгагдсан зорилтууд, холбогдох хууль тогтоомжийн зохицуулалттай уялдуулан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн **“Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого”**-ыг боловсруулсан болно.

Энэхүү хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилтуудад нийцүүлэн хот байгуулалт, барилгын салбарын үйл ажиллагааны шинэчлэлийг гүнзгийрүүлж, салбарын техникийн нэгдсэн бодлого, инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж шинэ түвшинд гаргах, импортыг орлох экспортын баримжаатай барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжиж, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй, материал, бүтээгдэхүүн, техник технологи нэвтрүүлэх замаар хүлэмжийн хийн ялгарал, эрчим хүчний хэрэглээ, дулаан алдагдлыг бууруулж, тогтвортой, ухаалаг, ногоон хот, ногоон барилгын үйл ажиллагааг эрчимтэй хөгжүүлэх арга замыг тодорхойлсон.

1.3. Бодлогын хамрах хүрээ:

- 1.1.1. Салбарын хууль эрх зүй, норм нормативын баримт бичиг;
- 1.1.2. Салбарын шинжлэх ухаан, техник технологи, инноваци;
- 1.1.3. Хот төлөвлөлт, барилга байгууламжийн зураг төсөл;
- 1.1.4. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, зах зээлийн бодлого;
- 1.1.5. Барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, ханган нийлүүлэлт;
- 1.1.6. Салбарын сургалт, хүний нөөц;
- 1.1.7. Орон сууц, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтэц;
- 1.1.8. Газрын харилцаа, геодези, зураг зүй

ХОЁР. БОДЛОГЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Бодлогын зорилго:

Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогын зорилго нь бүс нутаг, хот байгуулалтын хөгжлийн чиг хандлага, бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан барилгын салбарын хөгжлийг эрчимжүүлэх замаар хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

2.2. Бодлогын зорилгыг хангахад дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

2.2.1. Салбарын шинжлэх ухаан, техник технологийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, эрдэм шинжилгээ, судалгаанд суурилсан инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгоно.⁵

⁵ Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 67 дугаар тушаал, Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 8 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 129

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн конвенци болон Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын Протоколд нэгдэн орсон Талын хүлээсэн үүргийг биелүүлэх зорилгоор *Монгол Улсын Засгийн газраас* ТОГТООХ НЬ:

1. “Озоны үе давхаргыг хамгаалах Үндэсний хөтөлбөр”-ийг хавсралтын ёсоор баталсугай.
2. “Озоны үе давхаргыг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, уг асуудлаар яам, салбар хооронд зохицуулалт хийх үүрэг бүхий Озоны үндэсний хороо байгуулж ажиллахыг Байгаль орчны сайдын үүрэг гүйцэтгэгч С.Мэндсайханд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Р.АМАРЖАРГАЛ

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙДЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

С.МЭНДСАЙХАН

ОЗОНЫ ҮЕ ДАВХАРГЫГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Хүн төрөлхтөн химийн олон төрлийн үйлдвэрлэл эрхэлж, химийн олон төрлийн бодисуудыг аж амьдралдаа хэрэглэх болсноор озон задалдаг бодисыг үлэмж хэмжээгээр ялгаруулан агаар мандал дахь озоны давхарга хомсдох, улмаар нарны хэт ягаан туяаны хор хөнөөлд дэлхийн шим мандлын амьтан, ургамал, хүн ам их хэмжээгээр нэрвэгдэх аюулд тулгараад байна.

2. Монгол улс хүн төрөлхтний хөгжлийн нийтлэг хандлага болсон тогтвортой хөгжлийн чиг баримжаагаар байгаль орчныг тэтгэх даацандаа нийцүүлэн нийгэм, эдийн засгаа хөгжүүлэх бодлого баримталж байна.

3. Озоны давхаргыг хамгаалах тухай Венийн Конвенци, Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын Протокол болон тэдгээрт оруулсан 1990 оны Лондонгийн, 1992 оны Копенгагений нэмэлтүүдэд монгол улс нэгдэн орсон тул манай улс дээрх Конвенци, Протоколын албан ёсны Тал болсон болно.

4. Монгол улс озон задалдаг бодисын хэрэглээг үе шаттай бууруулж, улмаар бүрэн хязгаарлах нь дэлхийн хүн амын эрүүл мэнд, байгаль орчны таатай нөхцөлийг хадгалан хамгаалах чухал үйл хэрэг болохыг хүлээн зөвшөөрч, түүнийг хэрэгжүүлэх олон улсын хүчин чармайлтыг бүрэн дэмжин хувь нэмрээ оруулах зорилт тавин ажиллаж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, үе шат

5. Зорилго

Хөтөлбөрийн зорилго нь озоны давхаргыг задалдаг бодисын хэрэглээг үе шаттай бууруулж улмаар бүрмөсөн хязгаарлах, ашиглагдаж буй озон задалдаг бодисыг озоны давхаргыг үл задлах бодисоор орлуулахад оршино.

Үндэсний хөтөлбөр нь Венийн Конвенци, Монреалын Протоколоор Монгол улсын хүлээсэн үүргийг биелүүлэхэд бүрэн чиглэгдэнэ.

6. Үе шат

Хөтөлбөрийг дордурдсан үе шаттай хэрэгжүүлнэ:

а/ нэг дэх үе шат: 2005 оны 1 дүгээр сарын 1 хүртэл Монреалын Протоколын хавсралт А-ийн I бүлгийн хлорт фторт нүүрстөрөгчийн хэрэглээг 1997-1998 оны дундаж түвшнээс 50 хувь бууруулах;

б/ хоёр дахь үе шат: 2007 оны 1 дүгээр сарын 1 хүр-тэл Монреалын Протоколын хавсралт А-ийн I бүлгийн хлорт фторт нүүрстөрөгчийн хэрэглээг 85 хувь бууруулах;

в/ гуравдахь үе шат: 2010 оны 1 дүгээр сарын 1 хүртэл Монреалын Протоколын хавсралт А-ийн I бүлгийн хлорт фторт нүүрстөрөгчийн хэрэглээг бүрмөсөн хязгаарлах;

г/ дөрөв дэх үе шат: 2015 оны 1 дүгээр сарын 1 хүр-тэл Монреалын Протоколын хавсралт С-ийн I бүлгийн хлорт фторт нүүрстөрөгчийн хэрэглээг 1999

оны түвшнээс 90 хувь бууруулах;

д/ тав дахь үе шат: 2030 оны 1 дүгээр сарын 1 хүр-тэл Монреалын Протоколын хавсралт С-ийн I бүлгийн хлорт фторт нүүрстөрөгчийн хэрэглээг бүрмөсөн хязгаарлах.

Гурав. Удирдлага, зохион байгуулалт

7. Озоны давхаргыг хамгаалах асуудлыг Байгаль орчны сайдын дэргэд ажиллах озоны асуудлаархи Үндэсний хороо удирдан зохицуулна. Үндэсний хорооны бүрэлдэхүүнд нь Хөдөө аж ахуй, үйлдвэрийн, Дэд бүтцийн хөгжлийн болон, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, Үндэсний статистикийн газар, Гаалийн ерөнхий газар, Шинжлэх ухааны академи зэрэг төр, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөгчид орно.

8. Озоны асуудлаархи үндэсний хороо нь озоны давхаргыг хамгаалах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, озон задалдаг бодисын импорт, худалдаа, хэрэглээнд хяналт тавьж, тухайн асуудлаар эрх бүхий байгууллагаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

9. Озоны асуудлаархи үндэсний хорооны ажлын алба доорхи үүргийг гүйцэтгэнэ:

а/ хөтөлбөрт заасан үйл ажиллагааг зохион байгуулж явуулах;

б/ үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлыг олон улсын эрх бүхий байгууллагад тавьж, түүнийг хэрэгжүүлэх талаар технологи, санхүүгийн дэмжлэг, тусламж авах;

в/ озоны давхаргын шинжилгээ судалгаа, ажиглалт, хэмжилтийн ажлын чиглэл, хүрээг тогтоох, тэдгээрийг хариуцан гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

г/ озоны давхаргын өөрчлөлтөөс шалтгаалан хэт ягаан туяанаас шим мандалд үзүүлэх нөлөөллийг судлах ажлыг эрчимжүүлэх, энэ чиглэлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах;

д/ озоны давхаргыг шинжлэн судлах, хамгаалахтай холбоотой шинжлэх ухаан, нийгэм, эдийн засаг, худалдааны болон эрх зүйн мэдээллийг олон улсын эрх бүхий байгууллага, гадаад улстай солилцох, дотоодын сонирхсон байгууллагуудад түгээх, сурталчлах;

е/ озоны үе давхаргын талаархи Конвенци, Протоколын болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан гаргаж улирал бүр эрхэлсэн сайдад, жил бүрийн 1 дүгээр сард Засгийн газарт, гэрээ, хэлэлцээрт заасан хугацаанд нь олон улсын байгууллагад тайлагнах;

ж/ озоны давхаргыг задалдаг бодис хэрэглэдэг үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллага болон салбарын хэрэглээг бууруулах, өөр бодисоор орлуулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэхэд нь туслах, биелэлтэд хяналт тавих;

з/ озон задалдаг бодис хэрэглэдэг үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтнуудад зориулж сургалт семинар зохион байгуулах.

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Хөтөлбөрийн зорилгыг дор дурдсан үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ:

10. Зохион байгуулалтын талаар

а/ озоны давхаргыг хамгаалах эрх зүйн үндэс бүрдүүлэх;

б/ Монреалийн Протоколын 1997 оны нэмэлтэд нэгдэн орох;

в/ Байгаль орчны сайдын дэргэд Озоны асуудлаархи үндэсний хороо болон түүний ажлын албыг байгуулж ажиллуулах;

г/ озоны давхаргыг задалдаг бодис импортлогч, ашиглагч нарын үндэсний нийгэмлэг болон бусад холбогдох төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих, тэдгээртэй хамтран ажиллах;

д/ озоны давхаргыг шинжлэн судлах, хамгаалах төрийн болон төрийн бус байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх, хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр төсөл боловсруулан олон улсын байгууллагад тавьж хэрэгжүүлэх;

е/ озоны давхаргыг судлах, хамгаалах болон озон задалдаг бодисыг импортлогч, ашиглагч байгууллагын мэргэжилтнүүдэд зориулсан сургалт, семинар зохион явуулах;

ж/озоны давхаргыг задалдаг бодис ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудад олгох зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох;

з/ озон задалдаг бодисын хяналт-шинжилгээний үндэсний тогтолцоог бий болгох;

и/ озоны давхаргыг хамгаалах, озон задалдаг бодисын ялгаралтыг бууруулах, өөр бодис, технологиор орлуулах талаар олон нийтэд мэдээллийн бүх хэрэгслээр сурталчилгаа явуулах.

11. Судалгаа хэмжилтийн талаар

а/ хийн мандал дахь Озоны ерөнхий агууламж, түүний босоо тархалтын орон зай, цаг хугацааны өөрчлөлтийг хэмжих байнгын харуул байгуулан ажиллуулах;

б/ газрын гадаргаас завсрын мандал, давхраат мандал хүртэлх агаарын температурын хуваарилалтыг нарийвчлан судлах;

в/ газрын гадаргад ирж байгаа нарны цацрагийн долгионы бүрэлдэхүүн хийгээд амьд организмд нөлөөлөх хэт ягаан туяаны хэмжилт, судалгааны ажлыг зохион байгуулах;

г/ цаг уурын ажиглалт хэмжилтийн өндөр нарийвчлалтай багаж төхөөрөмжөөр уур амьсгалын өөрчлөлтийг судлах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхлэх.

12. Мэдээлэл солилцооны талаар

Озоны давхаргыг хамгаалах, озон задалдаг бодисын хэрэглээг багасгах, улмаар бүрмөсөн хязгаарлах зорилгоор олон улсын байгууллага, гадаад орон, дотоодын аж ахуйн нэгж, байгууллагатай дараахь мэдээлэл өгөгдлийг солилцоно:

а/ судалгаа явуулах шаардлага бүхий озоны давхаргыг задалдаг бодисын ялгарлын тухай өгөгдөл;

б/ озоны ерөнхий агууламж, түүний босоо чиглэл дэх хуваарилалтын тодорхой хугацааны өөрчлөлт хүний

эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн тухай шинжилгээ судалгааны үр дүн, мэдээлэл;

в/ шинжилгээ, судалгааны ажлын үр дүнгийн үнэлгээ, цаашдын судалгааны зөвлөмж;

г/ озон задалдаг бодисын ялгаралтыг бууруулах болон орлуулах бодис, технологийн талаархи судалгаа шинжилгээний ажлын мэдээлэл, тайлан;

д/ озон задалдаг бодисын үйлдвэрлэл, хэрэглээ, цаашдын хандлага, импорт, экспортын тухай мэдээлэл;

е/ озоны давхаргыг хамгаалахтай холбогдсон үндэсний хууль тогтоомж, удирдлага, зохицуулалтын талаархи мэдээлэл;

ж/ озоны давхаргыг хамгаалахтай холбогдсон лиценз, патент олгох нөхцөл, аргын тухай мэдээлэл.

13. Олон улсын хамтын ажиллагаа

Озоны давхаргыг хамгаалах, озон задалдаг бодисыг багасгах, бүрмөсөн хязгаарлах, озон хомсдуулдаг бодисын хэрэглээг өөр бодисоор орлуулан солих шинэ техник, технологи нэвтрүүлэх, озоны судалгаа шинжилгээ явуулах талаар олон улсын хамтын нийгэмлэгтэй харилцаа холбоогоо хөгжүүлж, түншлэлийн үр ашигтай хэлбэрээр хамтран ажиллана:

а/ ОХУ, АНУ, Канад, Австрали, Япон, ХБНГУ, БНХАУ, Франц зэрэг улс орнуудтай озоны давхаргын судалгаа шинжилгээ хамтран хийж, тандан судалгааны мэдээлэл хүлээн авах, солилцох, озон задалдаг бодисын мэдээлэл солилцох, орлуулагч бодисын мэдээлэл авах, шинэ технологи нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллах;

б/ озон задалдаг бодисын тооллого бүртгэл хийх, хөргөх системийн менежментийг сайжруулах зэрэг чиглэлээр НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Хөгжлийн хөтөлбөр, Үйлдвэр, хөгжлийн байгууллага, Озоны асуудлаархи олон талын сан, Дэлхийн экологийн сан зэрэг байгууллагатай хамтран ажиллах;

в/ озоны давхаргыг шинжлэн судлах, байнгын хяналт-шинжилгээ хийх, мэдээллийн сан, сүлжээ байгуулах, боловсон хүчин бэлтгэх чиглэлээр Дэлхийн цаг уурын байгууллага, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай үр ашигтай хамтын ажиллагааг улам бүр хөгжүүлэх;

г/ гадаад орон, олон улсын байгууллагатай хамтран озон задалдаг бодисын хэрэглээг өөрчлөх, орлуулагчаар солих, байгууллага, аж ахуйн нэгжийн мэргэжлийн хүмүүст сургалт явуулах, сонирхсон байгууллага, хүмүүст мэдээлэл сурталчилгаа явуулах төсөл боловсруулж хэрэгжүүлэх.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

14. Хөтөлбөрт заасан үйл ажиллагааг доорхи санхүүгийн эх үүсвэрээр хэрэгжүүлнэ:

а/ озон хомсдуулдаг бодисын тооллого болон хяналт шалгалтыг байгаль хамгаалахад зориулсан улсын төвлөрсөн болон орон нутгийн жил бүрийн төсвөөс санхүүжүүлнэ;

б/ үйлдвэр, үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах, байгаль орчинд халгүй технологи нэвтрүүлэх болон түүхий эд, материал ашиглахад зориулан үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагаас төлөвлөсөн хөрөнгө;

в/ хандивлагч орон, гадаад, дотоодын байгууллагын тусламжийн хөрөнгө

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт, үр дүн

15. Хяналт шалгалт: Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт тавих ажлыг Озоны асуудлаархи үндэсний хороо эрхлэн гүйцэтгэнэ.

16. Үр дүн

Озоны давхаргыг задалдаг бодисыг бүрэн хязгаарлах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

а/ озоны асуудлыг эрхлэх үндэсний удирдлага, зохицуулалтын тогтолцоо бүрэлдэн тогтож, озоны шинжилгээ судалгаа, байнгын ажиглалт хэмжилтийн тогтолцоо бий болно;

б/ монголын хүн ам, байгаль орчныг хэт ягаан туяаны нөлөөллөөс хамгаалах стратеги боловсруулах үндэслэл бүрдэж эхэлнэ;

в/ озоны талаархи эрх зүй, шинжлэх ухаан, техник, технологийн чиглэлийн дотоод, гадаадын мэдээллийн солилцоо тогтмолжино;

г/ Монгол улс Венийн Конвенци, Монреалын Протоколоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлнэ;

д/ уур амьсгалын өөрчлөлт болон хэт ягаан туяаны нөлөөлөлд бага автах хүнс тэжээлийн болон техникийн ургамал, тэжээмэл амьтан үржүүлэхэд шаардагдах мэдээллийн нэмэгдэл эх сурвалжтай болно;

е/ озоны давхаргыг үл задлах бодис хэрэглэх, байгаль орчинд халгүй технологи нэвтрүүлэхэд олон улсын дэмжлэг хүлээж, зохих тусламж авах бололцоо бүрдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 54

УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОСОН БОЛОН ЛИЦЕНЗТЭЙ НЭВТРҮҮЛЭХ БАРААНЫ КОДЛОСОН ЖАГСААЛТ, ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын “Гаалийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын 1998 оны 05 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны кодлосон жагсаалтыг 1 дүгээр, Монгол Улсын хилээр экспорт, импортын лицензтэй нэвтрүүлэх барааны кодлосон жагсаалтыг 2 дугаар, төрийн хяналтын дор улсын хилээр нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журмыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

4. Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралт, Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоолоор тусгайлан нэр зааснаас бусад бараанд гаалийн хяналт, бүрдүүлэлтийг зохих журмын дагуу хийж улсын хилээр экспорт, импортын лицензгүй нэвтрүүлж байхыг Улсын Гаалийн ерөнхий газрын дарга Х.Баатарт зөвшөөрсүгэй.

5. Энэхүү тогтоолыг 2001 оны 4 сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.ЭНХБАЯР

**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ
САЙД**

Ч.ГАНЗОРИГ

Засгийн газрын 2001 оны 54 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОСОН БАРААНЫ КОДЛОСОН ЖАГСААЛТ

Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн зүйл ¹	Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн мөр ¹	Барааны бичиглэл	Үндэслэл бүхий эрх зүйн акт	Улсын хилээр нэвтрүүлэх ялгаа
		<p>МОНГОЛ УЛСАД АШИГЛАХЫГ ХОРИГЛОСОН ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИС (судалгаа, шинжилгээний зориулалттай бодис хамаарахгүй):</p> <p><i>/Энэ хэсгийг ЗГ-ын 2014-12-1-ний өдрийн 378-р тогтоолоор дараах байдлаар өөрчлөн найруулсан/</i></p>	<p>"Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль /2006/", 2007 оны Засгийн газрын 95 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт</p>	Оруулах
	2903.79.10	Фтордихлорметан (HCFC-21 (CH ₂ FCl ₂) Dichloro fluoromethane)		
	2903.79.20	Фторхлорметан (HCFC-31 (CH ₂ FCl) Monochloro fluoromethane)		
	2903.79.90	Фтортетрахлорэтан (HCFC-121 (C ₂ HFC ₄) Tetrachloro fluorooethane)		
	2903.79.90	Дифтортрихлорэтан (HCFC-122 (C ₂ H ₂ F ₂ Cl ₃) Trichloro difluoroethane)		
	2903.79.30	Тетрафторхлорэтан (HCFC-124 (C ₂ H ₂ F ₄ Cl) Chloro tetra fluoroethane)		
	2903.79.90	Фтортрихлорэтан (HCFC-131 (C ₂ H ₂ FCl ₃) Trichloro fluorooethane)		

2903.79.90	Дифтордихлорэтан (HCFC-132b (C ₂ H ₂ F ₂ Cl ₂)) Dichlorodifluoroethane)		
2903.79.90	Трифторхлорэтан (HCFC-133a (C ₂ H ₂ F ₃ Cl)) Monochlorotrifluoroethane)		
2903.73.00	Фтордихлорэтан (HCFC-141 (C ₂ H ₃ FCl ₂)) (Dichlorofluoroethane)		
2903.73.00	Фтордихлорэтан (HCFC-141b CH ₃ CFCl ₂) (1,1-dichloro-1-fluoroethane)		
2903.79.90	Фторхлорэтан (HCFC-151 (C ₂ H ₄ FCI))		
2903.79.90	Фторгексахлорпропан (HCFC-221 (C ₃ HFCl ₆)) Hexachlorofluoropropane)		
2903.79.90	Дифторпентахлорпропан (HCFC-222 (C ₃ HF ₂ Cl ₅)) Pentachlorodifluoropropane)		
2903.79.90	Трифтортетрахлорпропан (HCFC-223 (C ₃ HF ₃ Cl ₄)) Tetrachlorotrifluoropropane)		
2903.79.90	Тетрафтортрихлорпропан (HCFC-224 (C ₃ HF ₄ Cl ₃)) Trichlorotetrafluoropropane)		
2903.75.00	Пентафтор-дихлорпропан (C ₃ HF ₅ Cl ₂ (HCFC -225))		
2903.75.00	Пентафтор-дихлорпропан (HCFC-225ca (C ₃ HF ₅ Cl ₂)) Dichloropentafluoropropane)		
2903.75.00	Пентафтор-дхлорпропан (HCFC-225cb (C ₃ HF ₅ Cl ₂)) Dichloropentafluoropropane)		
2903.79.90	Гексафторхлорпропан (HCFC-226 (C ₃ HF ₆ Cl)) Monochlorohexafluoropropane)		
2903.79.90	Фторпентахлорпропан (HCFC-231 (C ₃ H ₂ FCl ₅)) Pentachlorofluoropropane)		
2903.79.90	Дифтортетрахлорпропан (HCFC-232 (C ₃ H ₂ F ₂ Cl ₄)) Tetrachlorodifluoropropane)		
2903.79.90	Трифтортрихлорпропан (HCFC-233 (C ₃ H ₂ F ₃ Cl ₃)) Trichlorotrifluoropropane)		
2903.79.90	Тетрафтордихлорпропан (HCFC-234 (C ₃ H ₂ F ₄ Cl ₂)) Dichlorotetrafluoropropane)		

2903.79.90	Пентафторхлорпропан (HCFC-235 (C ₃ H ₂ F ₅ Cl) Monochloropentafluoropropane)			
2903.79.90	Фтортетрахлорпропан (HCFC-241 (C ₃ H ₃ FCl ₄) Tetrachlorofluoropropane)			
2903.79.90	Дифтортрихлорпропан (HCFC-242 (C ₃ H ₃ F ₂ Cl ₃) Trichlorodifluoropropane)			
2903.79.90	Трифтордихлорпропан (HCFC-243 (C ₃ H ₃ F ₃ Cl ₂) Dichlorotrifluoropropane)			
2903.79.90	Тетрафторхлорпропан (HCFC-244 (C ₃ H ₃ F ₄ Cl) Monochlorotetrafluoropropane)			
2903.79.90	Фтортрихлорпропан (HCFC-251 (C ₃ H ₄ FCl ₃) Monochlorotetrafluoropropane)			
2903.79.90	Дифтордихлорпропан (HCFC-252 (C ₃ H ₄ F ₂ Cl ₂) Dichlorodifluoropropane)			
2903.79.90	Трифторхлорпропан (HCFC-253 (C ₃ H ₄ F ₃ Cl) Monochlorotrifluoropropane)			
2903.79.90	Фтордихлорпропан (HCFC-261 (C ₃ H ₅ FCl ₂) Dichlorofluoropropane)			
2903.79.90	Дифторхлорпропан (HCFC-262 (C ₃ H ₅ F ₂ Cl) Monochlorodifluoropropane)			
2903.79.90	Фторхлорпропан (HCFC-271 (C ₃ H ₆ FCl) Monochlorofluoropropane)			
		АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ	Хог хаягдлын тухай хууль (2012) Хуулийн нэрийг ЗГ-ын 2014-12-1-ний өдрийн 378-р тогтоолоор өөрчилсөн.	Оруулах

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 296

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ БООМТЫН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 15.3-т
заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ
нь:

1. Химийн хорт болон аюултай бодисыг Монгол Улсын улсын
хилээр нэвтрүүлэх боомтын жагсаалтыг дор дурдсанаар
баталсугай:

а/ Дорноговь аймаг дахь Замын-Үүдийн боомт;

б/ Сэлэнгэ аймаг дахь Алтанбулагийн боомт;

в/ Сэлэнгэ аймаг дахь Сүхбаатар боомт;

г/ "Чингис хаан" олон улсын нисэх буудлын
хилийн шалган нэвтрүүлэх боомт.

д/ Дорнод аймаг дахь Баянхошууны боомт;

е/ Сүхбаатар аймаг дахь Бичигтийн боомт;

("д, е"- заалтыг 2007-03-20-ны 65-р тогтоолоор нэмсэн)

ж/ Өмнөговь аймаг дахь Гашуунсухайтын боомт.

2. Химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр
нэвтрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны сайд
И.Эрдэнэбаатар, Монгол Улсын сайд У.Хүрэлсүх, Улсын
гаалийн ерөнхий газрын дарга Б.Баттөмөр нарт үүрэг
болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД

И.ЭРДЭНЭБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 4 дүгээр
сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 95

ЖУРАМ, ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалтыг 1 дүгээр хавсралт, Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Монгол Улсад ашиглахыг хориглосон буюу хязгаарласан химийн хорт болон аюултай бодист хяналт тавих талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатар, Монгол Улсын сайд У.Хүрэлсүх, Улсын гаалийн ерөнхий газрын дарга (Б.БАТТӨМӨР) нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

**БАЙГАЛЬ ОРЧНЫ
САЙД**

И.ЭРДЭНЭБААТАР

Засгийн газрын 2007 оны 95 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСАД АШИГЛАХЫГ ХОРИГЛОСОН ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ЖАГСААЛТ

	Бодисын ердийн нэр	Химийн нэр, томъёо	Олонулсын бүртгэлийн дугаар (CAS)	Хэрэглээний түгээмэл хэлбэр	Бодисын онцлог, хоруу шинж чанар
8	Гексафторди-хлор пропан	Dichlorohexafluoro-propane; CFC-216 (C3F6Cl2)	2903-45-29	Хөргөлт	Озон задална.
9	Гептафторхлор пропан	Chloroheptafluoro-propane; CFC-217 (C3F7Cl)	2903-45-29	Хөргөлт	Озон задална.
17	Дифторбром-хлормэтан	Bromochlorodifluoro Methane; Halon-1211; (CF2BrCl)	2903-46-10	Хөргөлт	Озон задална.
18	Дифторгекса-хлор пропан	Hexachlorodifluoro-propane; CFC-212; (C3F2Cl6)	2903-45-29	Хөргөлт	Озон задална.
19	Дифтордихлор метан	Dichlorodifluoromethane; CFC-12*; (CF2Cl2)	2903-42-00	Хөргөх төхөөрөмж цэнэглэхэд	Озон задална.
20	Дифтортетра-хлор этан	Tetrachlorodifluoroethane, CFC-112; (C2F2 Cl4)	2903-45-21	Хөргөлт	Озон задална.
25	Метилхлорформ	1.1.1-trichloroethane; methyl chloroform; TCA/ MCF/ MC (C2H3Cl3)	2903-19-10	Техникийн эд ангийг цэвэрлэх, хуурай хими цэвэрлэгээ	Озон задална.
31	Пентафтортри-хлорпропан	Trichloropentafluoro-Propane; CFC-215; (C3F5Cl3)	2903-45-29	Хөргөлт	Озон задална.
32	Пентафторхлор-этан	Monochloropentafluoro-ethane; CFC-115*; (C2F5Cl)	2903-44-20	Хөргөлт	Озон задална.

37	1,1,2,2- тетрафтор дибром этан	Dibromotetrafluoroethane; Halon-2402; (C2F4Br2)	2903-46-30	Хөргөлт	Озон задална.
38	1,1,2,2- тетрафторди- хлорэтан	1.1.2.2-Dichlorotetrafluoro ethane; CFC-114; (C2F4Cl2)	2903-44-10	Хөргөлт	Озон задална.
39	Тetraфтортетра- хлорпропан	Tetrachlorotetrafluoropropane; CFC-214; (C3F3Cl4)	2903-45-29	Хөргөлт	Озон задална.
42	Трифторбром-метан	Bromotrifluoromethane; Halon-1301; (CF3Br)	2903-46-20	Хөргөлт	Озон задална.
43	Трифторпен- тахлорпропан	Pentachlorotrifluoro propane; CFC-213; (C3F3Cl5)	2903-45-29	Хөргөлт	Озон задална.
44	Трифторхлор метан	Chlorotrifluoromethane; CFC-13 (CF3Cl)	2903-45-11	Хөргөлт	Озон задална.
45	1,1,2-трифтор- трихлор этан	1.1.2-Trichlorotrifluoro ethane; CFC-113; (C2F3Cl3)	2903-43-00	Электрон төхөөрөмж, металл цэвэрлэхэд	Озон задална.
49	Фторпентахлор этан	Pentachlorofluoroethane; CFC-111; (C2FCl5)	2903-45-20	Хөргөлт	Озон задална.
50	Фторгептахлорпропан	Heptachlorofluoro-propane; CFC-211; (C3FCl7)	2903-45-29	Хөргөлт	Озон задална.
51	Фтортрихлор Метан	Trichlorofluoromethane; CFC-11* (CFCl3)	2903-41-00	Хөргөх төхөөрөмж цэнэглэхэд	Озон задална.
93	Фтордихлорметан	HCFC-21 (CHFCl ₂) Dichlorofluoromethane	75-43-4	Хөргөлт	Озон задална
94	Фторхлорметан	HCFC-31 (CH ₂ FCl) Monochlorofluoromethane	593-70-4	Хөргөлт	Озон задална
95	Фтортетрахлорэтан	HCFC-121 (C ₂ HFCl ₄) Tetrachlorofluoroethane	354-14-3	Хөргөлт	Озон задална
96	Дифтортрихлорэтан	HCFC-122 (C ₂ HF ₂ Cl ₃) Trichlorodifluoroethane	354-21-2	Хөргөлт	Озон задална
97	Тetraфторхлорэтан	HCFC-124 (C ₂ HF ₄ Cl) Chlorotetrafluoroethane	2837-89-0	Хөргөлт	Озон задална
98	Фтортрихлорэтан	HCFC-131 (C ₂ H ₂ FCl ₃) Trichlorofluoroethane	359-28-4	Хөргөлт	Озон задална
98	Дифтордихлорэтан	HCFC-132b (C ₂ H ₂ F ₂ Cl ₂) Dichlorodifluoroethane	1649-8-7	Хөргөлт	Озон задална
100	Трифторхлорэтан	HCFC-133a (C ₂ H ₂ F ₃ Cl) Monochlorotrifluoroethane	75-88-7	Хөргөлт	Озон задална
101	Фтордихлорэтан	HCFC-141 (C ₂ H ₃ FCl ₂) Dichlorofluoroethane	430-57-9	Хөргөлт	Озон задална
102	Фтордихлорэтан	HCFC-141b CH ₃ CFCl ₂ 1,1-dichloro-1- fluoroethane	1717-0-6	Хөргөлт	Озон задална

103	Фторхлорэтан	HCFC-151 (C ₂ H ₄ FCI)	110587-14-9	Хөргөлт	Озон задална
104	Фторгексахлорпропан	HCFC-221 (C ₃ HFCl ₆) Hexachlorofluoropropane	422-26-4	Хөргөлт	Озон задална
105	Дифторпентахлорпропан	HCFC-222 (C ₃ HF ₂ Cl ₅) Pentachlorodifluoropropane	422-49-1	Хөргөлт	Озон задална
106	Трифтортетрахлорпропан	HCFC-223 (C ₃ HF ₃ Cl ₄) Tetrachlorotrifluoropropane	422-52-6	Хөргөлт	Озон задална
107	Тетрафтортрихлорпропан	HCFC-224 (C ₃ HF ₄ Cl ₃) Trichlorotetrafluoropropane	422-54-8	Хөргөлт	Озон задална
108	Пентафтор-дихлорпропан	C ₃ HF ₅ Cl ₂ (HCFC -225)	127564-92-5	Хөргөлт	Озон задална
109	Пентафтор-дихлорпропан	HCFC-225ca (C ₃ HF ₅ Cl ₂) Dichloropentafluoropropane	422-56-0	Хөргөлт	Озон задална
110	Пентафтор-дхлорпропан	HCFC-225cb (C ₃ HF ₅ Cl ₂) Dichloropentafluoropropane	507-55-1	Хөргөлт	Озон задална
111	Гексафторхлорпропан	HCFC-226 (C ₃ HF ₆ Cl) Monochlorohexafluoropropane	431-87-8	Хөргөлт	Озон задална
112	Фторпентахлорпропан	HCFC-231 (C ₃ H ₂ FCI ₅) Pentachlorofluoropropane	421-94-3	Хөргөлт	Озон задална
113	Дифтортетрахлорпропан	HCFC-232 (C ₃ H ₂ F ₂ Cl ₄) Tetrachlorodifluoropropane	460-89-9	Хөргөлт	Озон задална
114	Трифтортрихлорпропан	HCFC-233 (C ₃ H ₂ F ₃ Cl ₃) Trichlorotrifluoropropane	7125-84-0	Хөргөлт	Озон задална
115	Тетрафтордихлорпропан	HCFC-234 (C ₃ H ₂ F ₄ Cl ₂) Dichlorotetrafluoropropane	425-94-5	Хөргөлт	Озон задална
116	Пентафторхлорпропан	HCFC-235 (C ₃ H ₂ F ₅ Cl) Monochloropentafluoropropane	460-92-4	Хөргөлт	Озон задалн
117	Фтортетрахлорпропан	HCFC-241 (C ₃ H ₃ FCI ₄) Tetrachlorofluoropropane	666-27-3	Хөргөлт	Озон задална
118	Дифтортрихлорпропан	HCFC-242 (C ₃ H ₃ F ₂ Cl ₃) Trichlorodifluoropropane	460-63-9	Хөргөлт	Озон задална
119	Трифтордихлорпропан	HCFC-243 (C ₃ H ₃ F ₃ Cl ₂) Dichlorotrifluoropropane	460-69-5	Хөргөлт	Озон задална
120	Тетрафторхлорпропан	HCFC-244 (C3H3F4Cl) Monochlorotetrafluoropropane	679-85-6	Хөргөлт	Озон задална
121	Фтортрихлорпропан	HCFC-251 (C3H4FCI3) Monochlorotetrafluoropropane	421-41-0	Хөргөлт	Озон задална
122	Дифтордихлорпропан	HCFC-252 (C3H4F2CI2) Dichlorodifluoropropane	819-00-1	Хөргөлт	Озон задална
123	Трифторхлорпропан	HCFC-253 (C3H4F3CI) Monochlorotrifluoropropane	460-35-5	Хөргөлт	Озон задална
124	Фтордихлорпропан	HCFC-261 (C3H5FCI2) Dichlorofluoropropane	420-97-3	Хөргөлт	Озон задална
125	Дифторхлорпропан	HCFC-262 (C3H5F2CI) Monochlorodifluoropropane	421-02-03	Хөргөлт	Озон задална
126 ¹	Фторхлорпропан	HCFC-271 (C3H6FCI) Monochlorofluoropropane	430-55-7	Хөргөлт	Озон задална

Засгийн газрын 2007 оны дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

**МОНГОЛ УЛСАД АШИГЛАХЫГ ХЯЗГААРЛАСАН
ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН
ЖАГСААЛТ**

	Бодисын ердийн нэр	Химийн нэр, томъёо	Олон улсын бүртгэлийн дугаар (CAS)	Хэрэглээний түгээмэл хэлбэр	Бодисын онцлог, хоруу шинж чанар
4	4 хлорт нүүрстөрөгч	Carbon tetrachloride, (CCl ₄)	2903-14-00	Агрохимийн бодис, эм, тос үйлдвэрлэх, судалгаа шинжилгээ хийхэд	Озон задална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 6 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 199

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 10.6, 11.2, 11.4, 11.5, 12, 14-20 дугаар зүйл, 21.1.2-21.1.30, 22, 24 дүгээр зүйл, 25.1.2, 25.1.3, 25.1.7-25.1.9, 26.1.6-26.1.9, 26.2, 26.3, 27.1.1, 27.1.4-27.1.6, 27.2-27.4, 28, 29 дүгээр зүйл, 30.2.2-30.2.6, 30.3-30.5 дахь хэсэг, 31-33 дугаар зүйл, 35.1.1-35.1.3, 37, 40 дүгээр зүйлд заасан тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2. 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдөр батлагдсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 7, 8 дугаар зүйлд заасны дагуу энэхүү тогтоолоор бууруулж тогтоосон тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс, бусад тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭ

Арван нэг. Байгаль орчны чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

11.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21.1.2-21.1.30-д заасан байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

11.1.8. озон задалдаг бодисыг системээс юүлэх, цэвэрлэх, дахин цэнэглэх, засвар үйлчилгээ хийх, устгах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

11.1.9. озоны давхаргыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, байгаль орчинд ээлтэй бодис импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл олгоход 27 000 төгрөг;

11.1.10. озон задалдаг бодисын хольц агуулсан дараахь тоног төхөөрөмж импортлох, худалдах зөвшөөрөл олгоход:

11.1.10.а. гэр ахуйн хөргөгч, хөлдөөгч 25 000 төгрөг;

11.1.10.б. иргэн, олон нийтийн барилга, орон сууцны агааржуулагч, хөргөх хэрэгсэл 50 000 төгрөг;

11.1.10.в. үйлдвэр болон томоохон зочид буудлын хөргөх систем 100 000 төгрөг;

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 8 дугаар
сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 303

ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд халгүй техник, тоног төхөөрөмжийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Сангийн сайд Ч.Улаан, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**БАЙГАЛЬ ОРЧИН,
НОГООН ХӨГЖЛИЙН САЙД**

С.ОЮУН

Засгийн газрын 2013 оны 303 дугаар
тогтоолын хавсралт

**БАЙГАЛИЙН НӨӨЦИЙГ ХЭМНЭЛТТЭЙ
АШИГЛАХ, ОРЧНЫ БОХИРДОЛ, ХАЯГДЛЫГ
БАГАСГАХ, БАЙГАЛЬД ХАЛГҮЙ ТЕХНИК, ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ**

№	БТКУС-ийн код	Тоног, төхөөрөмжийн нэр
7	2711.12.00	R-290 (Propane) бүхий хөргөлтийн тоног төхөөрөмж
8	2903.39.90	R-32 (Difluoromethane) бүхий хөргөлтийн тоног төхөөрөмж
9	2903.39.90	R-152a (Difluoroethane) бүхий хөргөлтийн тоног төхөөрөмж
10	2811.21.00	R-744 (Carbon dioxide) бүхий хөргөлтийн тоног төхөөрөмж

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 9 дүгээр
сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 290

ЖУРАМ, ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын үүрэг гүйцэтгэгч Д.Оюунхоролд даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 1998 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 95 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ** **Ж.ЭРДЭНЭБАТ**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ** **Д.ОЮУНХОРОЛ**

БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ДЭВШИЛТЭТ АРГА, ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛСЭН ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫГ УРАМШУУЛАХ ЖУРАМ

Гурав. Урамшууллын шалгуур үзүүлэлт

3.1. Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулахад дараах чиглэлийг баримтална:

3.3.2. хог хаягдлыг багасгах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ангилан ялгах, дахин болон сэргээн ашиглах, устгах дэвшилтэт технологи нэвтрүүлсэн, хаягдал дахь хорт бодисын агууламжийг бууруулсан байх;

3.4. Хүлэмжийн хийг бууруулах, эрчим хүчийг хэмнэх чиглэлээр дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

3.4.3. нар, салхи болон газрын гүний дулааныг ашиглах технологи, дулаалгын материал, халаах, хөргөх болон агааржуулах систем зэрэг байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй технологи, тоног төхөөрөмж импортоор авсан, эсхүл үйлдвэрлэж зах зээлд тогтвортой нийлүүлсэн байх;

3.5. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулсан, байгальд ээлтэй түүхий эд материал ашиглаж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнд олгох “Эко тэмдэг”-ийн шалгуур үзүүлэлт болон түүнийг үнэлэх аргачлалыг энэхүү журмын 5.3-т заасан Техникийн зөвлөл боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 5 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 116

ЖУРАМ, ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

Хог хаягдлын тухай хуулийн 7.1.2, 7.1.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам”-ыг 1 дүгээр, “Аюултай хог хаягдлын жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 135 дугаар тогтоол, “Жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 264 дүгээр тогтоол, “Аргачлал батлах тухай” Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 288 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Н.ЦЭРЭНБАТ

Засгийн газрын 2018 оны 116 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ЖАГСААЛТ

Бүлгийн код	Хог хаягдлын бүлэг	Дэд бүлгийн код	Хог хаягдлын дэд бүлэг	Хог хаягдлын төрлийн код	Хог хаягдлын төрөл	Аюулын зэрэглэл
14.	Органик уусгагч, хөргүүрийн шингэн болон хөөс/аэрозолийн хаягдал (Ё, Ж ангиллын хаягдал хамаарахгүй)	14 01	Органик уусгагч, хөргүүрийн шингэн болон хөөс/аэрозолийн хаягдал	14 01 01*	Хлорфторт нүүрстөрөгч, HCFC, HFC	A
				14 01 02*	Бусад галоген агуулсан уусгагч болон уусгагчийн холимог	A
				14 01 04*	Галогент уусгагч агуулсан лаг болон хатуу хаягдал	A
16.	Бусад хог хаягдал	16 02	Цахилгаан болон цахим тоног төхөөрөмжийн хаягдал	16 02 03*	Хлор фторт нүүрстөрөгчид, HCFC, HFC агуулсан хаягдал тоног төхөөрөмж	X
20	Ахуйн хог хаягдал (түүнтэй найрлага, бүтцийн хувьд ижил үйлдвэр, үйлчилгээ, албан байгууллагын хог хаягдал)	20 01	Ангилж цуглуулсан хог хаягдал (15 01 -ээс бусад)	20 01 12*	Хлорфторт нүүрстөрөгчид агуулсан хаягдал тоног төхөөрөмж, хэрэгсэл	X

Тайлбар⁵:

- Аюултай хог хаягдлыг “А” гэсэн тэмдэглэгээгээр тэмдэглэх бөгөөд ийм тэмдэглэгээтэй хог хаягдлыг шууд аюултай хог хаягдал гэж үзнэ.
- “Хяналттай” хог хаягдлыг “Х” гэсэн тэмдэглэгээгээр тэмдэглэх бөгөөд ийм хог хаягдал нь 2 дугаар хүснэгтэд заасан аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг 3 дугаар хүснэгтэд заасан босго түвшинтэй тэнцүү болон түүнээс их хэмжээгээр агуулж байвал “аюултай” хог хаягдал гэж үзнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 5 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 157

ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн хуулийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: 1. Гаалийн албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх агаар цэвэршүүлэгч, эрчим хүчний хэмнэлттэй халаагч төхөөрөмжийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай. 2. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат нарт тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Н.ЦЭРЭНБАТ

**ГААЛИЙН АЛБАН ТАТВАР, НЭМЭГДСЭН
ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ АГААР
ЦЭВЭРШҮҮЛЭГЧ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ
ХАЛААГЧ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ**

1. Агаар цэвэршүүлэгч

№	БТКУС-ийн код	Төхөөрөмжийн нэр
1.1.	8415.10.00	Цонх, хана, тааз эсвэл шаланд бэхлэх зориулалтаар зохион бүтээгдсэн, нэг гэрт угсрагдсан эсвэл “хуваарилах систем”-тэй агааржуулагч төхөөрөмж
1.2.	8415.81.00	Хөргөх төхөөрөмжтэй, агаарын хүйтэн/дулаан урсгалын эргэлтийг тохируулах хавхлага, тохируулгад дулааны насос бүхий агааржуулагч төхөөрөмж

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 9 дүгээр
сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 277

ЖУРАМ, ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

Агаарын тухай хуулийн 25.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Озон задалдаг бодисын жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт, “Озон задалдаг бодисыг орлуулах бодисын жагсаалт”-ыг 3 дугаар хавсралт, “Озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис агуулсан тоног төхөөрөмжийн жагсаалт”-ыг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Гаалийн ерөнхий газар Б.Асралт, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар Н.Цагаанхүү нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 1999 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн “Журам батлах тухай” 104 дүгээр тогтоолыг 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолыг 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Н.ЦЭРЭНБАТ

ОЗОН ЗАДАЛДАГ БОДИС БОЛОН БУСАД ОРЛУУЛАХ БОДИС ТЭДГЭЭРИЙГ АГУУЛСАН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ИМПОРТЛОХ, ХУДАЛДАХ АШИГЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын нэгдэн орсон “Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн конвенц”, “Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн протокол”-оор хүлээсэн үүргийг биелүүлэх, “Озоны үе давхаргыг хамгаалах тухай” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор озон задалдаг бодис болон дэлхийн дулааралд сөрөг нөлөөтэй бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, тухайн жилийн тоо хэмжээг тогтоох, хэрэглээнд хяналт тавих харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журам нь Агаарын тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Хог хаягдлын тухай, Зөрчлийн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тавих шаардлага

2.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах ерөнхий шаардлага

2.1.1. “Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийг мөрдөх;

2.1.2. хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, химийн хортой болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулахад тавих ерөнхий шаардлага MNS:6458:2014 стандартыг хангасан байх;

2.1.3. озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис ашиглан хөргөлт, агааржуулалтын засвар, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага нь мэргэшлийн гэрчилгээтэй засварчин, инженер, техникийн ажилтантай байх;

2.1.4. озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг импортлох тоо хэмжээнд багтсан аж ахуйн нэгж, байгууллага нь өмнөх оны импортолсон, худалдсан, ашигласан бодисын зарцуулалт, хэрэглээ, түүнийг агуулсан тоног төхөөрөмжийн борлуулалт, нийлүүлэлтийн тухай холбогдох тайланг маягтын дагуу гаргаж, жил бүрийн 12 дугаар сарын 30-ны дотор Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх;

2.1.5. энэ зүйлийн 2.1.4-т заасан хугацаанд шинээр байгуулагдсан хуулийн этгээдээс бусад тайлангаа ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагад дараа жилийн импортын тоо, хэмжээнд хамрагдах эрх үүснэ.

2.2. Озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис худалдахад тавих шаардлага:

2.2.1. ашиглах зөвшөөрөлгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад бодисыг худалдахгүй байх;

2.2.2. тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис худалдахдаа худалдан авсан этгээдийн хаяг, бодисын нэр, төрөл, хэмжээ, ашиглах зориулалтыг заасан баримтыг 2 хувь үйлдэн баталгаажуулж, нэг хувийг худалдан авагчид, үлдсэн хувийг өөртөө хадгалах;

2.2.3. бодис нь зориулалтын сав, баглаа боодол, стандартын шаардлага хангасан англи, орос, монгол хэл дээр үйлдэгдсэн хаяг, шошготой байх;

2.2.4. бодисыг худалдахдаа худалдан авагчид тухайн бодисын хор, аюулгүй ажиллагааны лавлах мэдээллийг заавал дагалдуулан өгөх; 2.2.5. бодисыг жижиглэн худалдахдаа зориулалтын, тодорхой хаяг шошго бүхий саванд савласан байх;

2.2.6. бодисыг анхааруулах тэмдэг бүхий зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх бөгөөд тээвэрлэх, ачих, буулгах үеийн аюулгүй ажиллагааг худалдах үйл ажиллагаа эрхлэгч хариуцах;

126	Нүүрсүстөрөгчийн хольц	R-1150	Ethylene(C ₂ H ₄)	Этилен	74-85-1	20	2711.14**	Хөргөх бодис (Тодорхойгүй)

Тайлбар: Пропилен нь 90 хувиас дээш цэвэршилттэй бол БТКУС код нь 2901.22.00

Пропилен нь 90 хувиас доош цэвэршилттэй бол БТКУС код нь 2711.14.00

Этилен /ханаагүй нүүрсүстөрөгч/ нь 95 хувиас доош цэвэршилттэй бол БТКУС код нь 2711.14.00

Этилен /ханаагүй нүүрсүстөрөгч/ нь 95 хувиас дээш цэвэршилттэй бол БТКУС код нь 2901.21.00

Засгийн газрын 2018 оны 277 дугаар
тогтоолын 4 дүгээр хавсралт

**ОЗОН ЗАДАЛДАГ БОДИС БОЛОН
БУСАД ОРЛУУЛАХ БОДИС АГУУЛСАН
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ**

Д/д	БТКУС-ийн код	Бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийн нэр	ОЗБ болон орлуулах бодисын төрөл
I БҮЛЭГ			
1.		Озоны давхарга, дэлхийн дулааралд сөрөг нөлөө бүхий HCFC-22, HCFC-141b бодисоор хөөсөнцөр үйлдвэрлэх тоног төхөөрөмж (Засгийн газрын 2001 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны кодолсон жагсаалт”-д орсон)	
II БҮЛЭГ			
1.	8415.10.00	Цонх, хана, тааз, эсхүл шаланд бэхлэх зориулалттай зохион бүтээгдсэн нэг гэрт угсрагдсан, эсхүл “хуваарилах систем”-тэй агааржуулагч төхөөрөмж	HCFC-22, R-410A, R-407C, HFC-161, HFC-32, HC-290 болон бусад
2.	8415.20.00	Тээврийн хэрэгслийн агааржуулагч	
3.	8415.81.00	Хөргөх төхөөрөмжтэй, агаарын хүйтэн/дулаан урсгалын эргэлтийг тохируулах хавхлагатай (тохируулгатай дулааны насос) агааржуулагч төхөөрөмж	
4.	8415.82.00	Хөргөх төхөөрөмжтэй, агаарын хүйтэн/дулаан урсгалын эргэлтийг тохируулах хавхлагатайгаас бусад агааржуулагч төхөөрөмж	
5.	8415.90.00	Агааржуулагчийн мотор	

6.	8418.10.00	Тусдаа хаалгатай хөргөгч-хөлдөөгч	
7.	8418.21.00	Ахуйн зориулалтын шахуургат хөргөгч	HFC-134a,
8.	8418.29.00	Ахуйн зориулалттай, шахуургатайгаас бусад төрлийн хөргөгч	HC-600a,
9.	8418.30.00	800 л-ээс ихгүй багтаамжтай, хайрцаг маягийн хөлдөөгч	HC-290 болон бусад
10.	8418.40.00	900 л-ээс ихгүй багтаамжтай, босоо байрлалтай хөлдөөгч	
11.	8418.50.10	Хөргөх, эсхүл хөлдөөх төхөөрөмжөөр тоноглогдсон тавцан	R-404A,
12.	8418.50.20	Хөргөх, эсхүл хөлдөөх төхөөрөмжөөр тоноглогдсон лангуу	HFC-134a, HC-290,
13.	8418.50.30	Хөргөх, эсхүл хөлдөөх төхөөрөмжөөр тоноглогдсон шүүгээ	R-744(CO ₂),
14.	8418.50.90	Хөргөх, эсхүл хөлдөөх төхөөрөмжөөр тоноглогдсон, хадгалах болон үзүүлэнгийн зориулалттай бусад тавилга	R-717, R-507A болон бусад
15.	8418.61.00	Зүйл 84.15-ын агааржуулагч төхөөрөмжөөс бусад дулааны насос	R-404A,
16.	8418.69.00	Хөргөх, эсхүл хөлдөөх бусад төхөөрөмж	HFC-134a
17.	8418.99.10	Хөргөх, эсхүл хөлдөөх төхөөрөмжийн мотор	R-744, R717 болон бусад
18.	8414.30.00	Хөргөх төхөөрөмжийн зориулалттай компрессор	
19.	8419.60.00	Агаар, эсхүл бусад хийг шингэрүүлэх төхөөрөмж	R-404A, HFC-134a болон бусад

20.	8424.10.00	Гал унтраагч	HFC-227ea, HFC-12, HFC-23 болон бусад
21.	8476.21.00	Ундаа худалдах автомат машин	R-404A,
22.	8476.81.00	Барааг автоматаар худалдах зориулалтын халаах, эсхүл хөргөх төхөөрөмжтэй бусад машин	HFC-134a R-744 болон бусад
23.	8451.10.00	Хуурай хими цэвэрлэгээний тоног төхөөрөмж	Нүүрстөрөгчид, (HCs), R-744 болон бусад
24.	8477.10.00	Озоны давхаргад халгүй, дэлхийн дулааралд сөрөг нөлөөлөх чадвар багатай орлуулах бодисыг хөөсрүүлэгчээр ашиглан хөөсөнцөр үйлдвэрлэх зориулалттай даралтаар хэвлэх машин	HFC-134a, HFC-152a,
25.	8477.20.00	Озоны давхаргад халгүй, дэлхийн дулааралд сөрөг нөлөөлөх чадвар багатай орлуулах бодисыг хөөсрүүлэгчээр ашиглан хөөсөнцөр үйлдвэрлэх зориулалттай шахан цувих машин (экструдер)	HFO-1234ze болон бусад HFC-245fa, HFC-365mfc/ HFC-227ea
26.	8477.30.00	Озоны давхаргад халгүй, дэлхийн дулааралд сөрөг нөлөөлөх чадвар багатай орлуулах бодисыг хөөсрүүлэгчээр ашиглан хөөсөнцөр үйлдвэрлэх зориулалттай үлээлгэн хэв оруулах машин	HFO-1233zd HFO-1336mzz болон бусад

27.	8609.00.00	Хөргүүртэй чингэлэг	HFC-134a, HFC-452A, HFC-404A, HFC-513A, R-744, HFC-290
28.	3907.20.00	Полиол, полиолын холимог	Циклопентаны хольц
29.	3909.50.00	Полиуретан	(Cyclopentane Blends) R-611 (Methyl Formate)
30.	3921.11.00	Стиролын полимерын хавтан, хуудас, тууз	Диметоксиметан
31.	3921.13.00	Полиуретан хавтан, хуудас, тууз	(Methylal) HFO-1234ze(E) болон бусад Диметилийн эфир (Di-methyl Ether- R-E170) HFC-152a HFC-227ea, HFC-245fa, HFC-365mfc HC-601a, R-1130(E)

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2009 оны 08 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 217/259

ХЛОРТФТОРТ НҮҮРСТӨРӨГЧ АГУУЛСАН ИНГАЛЯЦИ ХЭЛБЭРИЙН ЭМИЙН БҮРТГЭЛИЙГ ЗОГСООХ ТУХАЙ

Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн Конвенци Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн Протоколын Талуудын хоёрдугаар хурлаас гаргасан Монреалийн протоколын" А" хавсралтын нэгдүгээр бүлгийн хлортфорт нүүрстөрөгчийн үйлдвэрлэл, хэрэглээг 2010 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн бүр мөсөн хориглох тухай шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Гуурсан хоолойн багтраа болон уушигны архаг бөглөрөлтөт өвчний үед хэрэглэдэг хлортфорт нүүрстөрөгч агуулсан ингаляци хэлбэрийн эмийг улсын бүртгэлд шинээр бүртгэх, бүртгэлийн хугацааг сунгахыг 2009 оны наймдугаар сарын 15-наас зогсоосугай.

2. Холбогдох дүрэм журамд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар озоны давхаргад халгүй орлуулагч бодис бүхий ингаляци хэлбэрийн эмийг захиалах, бүртгэх, импортлох ажлыг 2009 оны 12 дугаар сарын 15-ны дотор зохион байгуулахыг Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэс /Ч.Мэнхдэлгэр/-т даалгасугай.

3. Энэхүү тушаалыг аймаг, нийслэлд хүргүүлэх, сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Байгаль, орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар (Д.Энхбат), Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэс /Ч. Мөнхдэлгэр/-т үүрэг болгосугай.

**БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Л.ГАНСҮХ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЛАМБАА

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН ХАМТАРСАН
ТУШААЛ**

2009 оны 11 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 334/104

**ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ
/Химийн хорт болон аюултай бодис экспортлох,
импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон
үйлдвэрлэх, худалдах/**

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн
6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Химийн хорт болон аюултай бодис экспортлох,
импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх,
худалдах журмыг хавсралтын ёсоор баталсугай.

Хоёр. Энэхүү журмыг аймаг, нийслэлд хүргүүлэх,
сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг
Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн
буй орчин, байгалийн нөөцийн газар /Д.Энхбат/-т үүрэг
болгосугай.

Гурав. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан
“Журам батлах тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын
сайд, Гадаад харилцааны сайдын хамтарсан 2008 оны
12 дугаар сарын 29-ний өдрийн 92/90 дүгээр хамтарсан
тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

**БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Л.ГАНСҮХ

**ГАДААД ХАРИЛЦААНЫ
САЙД**

Г.ЗАНДАНШАТАР

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Гадаад харилцааны сайдын 2009 оны
334/104 дүгээр хамтарсан тушаалын хавсралт

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИС ЭКСПОРТЛОХ, ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ БОЛОН ҮЙЛДВЭРЛЭХ, ХУДАЛДАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Химийн хорт болон аюултай бодисын тухай” Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, 8,9,11,15,18 дугаар зүйлд заасан химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах зөвшөөрөл /цаашид зөвшөөрөл гэх/ олгох, тэдгээрт тавих шаардлага болон экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах үед химийн хорт болон аюултай бодисоос хамгаалах эрх зүйн хэм хэмжээг тогтоон зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.3. Озон задалдаг бодисыг импортлох, худалдах, ашиглахтай холбогдсон үйл ажиллагааг Засгийн газрын “Озон задладаг бодисыг импортлох, ашиглах зөвшөөрөл олгох журам”-аар зохицуулна.

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ**

2015 оны 10 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар А356/396

**ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН
АНГИЛАЛ БАТЛАХ ТУХАЙ**

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Химийн хорт болон аюултай бодисын ангиллыг 1 дүгээр, Химийн хорт болон аюултай бодисын ангиллыг ашиглах аргачлалыг 2 дугаар, Химийн хорт болон аюултай бодисын ангилалд хамруулсан бодисын жагсаалтыг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Ангилал батлах тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 04/04 дүгээр хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Н.БАТЦЭРЭГ

**ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН
САЙД**

Г.ШИЙЛЭГДАМБА

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд,
Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн
А/356/396 дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН АНГИЛЛЫГ АШИГЛАХ АРГАЧЛАЛ

ОРШИЛ

Шинжлэх ухаан, технологи хурдацтай хөгжиж буй өнөө үед химийн бодисын нэр төрөл, хэрэгцээ шаардлага жилээс жилд өсөн нэмэгдэж, үүнтэй уялдан химийн бодисоор байгаль орчин бохирдох, хүний эрүүл мэндэд хор нөлөөлөл үзүүлэх тохиолдлууд гарах боллоо. Химийн бодисын зохистой хэрэглээг бий болгож, түүний хор нөлөөллөөс хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалахад дэлхийн улс орнууд ихээхэн анхаарал хандуулан, хэд хэдэн гэрээ, конвенцийг гаргаад байна.

Химийн бодисын ашиглалт, тээвэрлэлт, хадгалалтын үеийн аюулгүй ажиллагааг хангах, химийн бодис бүрээр нэгдсэн нэг ойлголттой байх зорилгоор НҮБ-аас 1999 онд “НҮБ-ын аюултай ачаа тээвэрлэх зөвлөмж, аргачилсан заавар”, түүний дагалдах боть болох “НҮБ-ын аюултай ачаа тээвэрлэх зөвлөмж. Туршилт, шалгуурын гарын авлага”, 2003 онд “Химийн бодисын ангилал, хаягжуулалтын нэгдсэн систем”-ийг тус тус батлан гаргасан ба 2013 онд “Химийн бодисын ангилал, хаягжуулалтын нэгдсэн систем”-ийг шинэчлэн гаргасан байна.

Химийн аюулгүй байдлын тухай засгийн газар хоорондын форум, Тогтвортой хөгжлийн тухай дэлхийн дээд хэмжээний уулзалтуудаас “Химийн бодисын ангилал, хаягжуулалтын нэгдсэн систем”-ийг 2008 он гэхэд дэлхий нийтээр мөрдөх зорилтыг тавьсан бөгөөд ингэснээр химийн бодис бүрийг шинж чанар, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөгөөр нь цогц

тодорхойлон, ангилалд хамруулж, нэгдсэн, товч, тодорхой хаяг шошгийг ашиглах боломжийг бүрдүүлсэн юм.

Монгол Улсын Их хурлаас 2006 онд батласан “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн 4.1-д химийн бодисыг уг ангиллын дагуу хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд үзүүлэх нөлөөллөөр нь хортой ба аюултай гэж ангилахаар заасан билээ.

Дээр дурдсан баримт бичгүүдэд нийцүүлэн Монгол Улсад мөрдөгдөх химийн хорт болон аюултай бодисын ангилал болон уг ангиллыг ашиглахад шаардагдах мэдээлэл, нэр томьёо, тодорхойлолт, тайлбарыг агуулсан аргачлалыг боловсруулан гаргаж байна.

2. ХИМИЙН БОДИС БОЛОН ХОЛЬЦЫГ АНГИЛАХ

Химийн бодисын ангиллын “**химийн бодис**” гэсэн ухагдахуунд зөвхөн химийн элемент, нэгдлүүдээс гадна химийн бодисын хольцыг хамруулна.

Бодис гэж бүтээгдэхүүний тогтвортой байдлыг хангахад шаардлагатай аливаа нэмэлт болон үйлдвэрлэсэн аргаасаа хамаарч аливаа хольцыг агуулсан байгалийн төлөв байдалд байгаа болон үйлдвэрлэлийн аргаар гарган авсан бүх химийн элемент, тэдгээрийн нэгдлүүдийг хэлнэ. Энд бодисын тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр болон түүний бүтцийг өөрчлөхгүйгээр зайлуулж болох аливаа уусгагч хамаарахгүй.

Хольц гэж хоорондоо урвалд ордоггүй хоёр болон түүнээс дээш бодисоос бүрдсэн хатуу бодис эсвэл уусмалыг хэлнэ.

Хольцыг бүрдүүлж буй бодисууд нь нэг ижил шинж чанартай байвал түүнийг нэг төрлийн бодис гэж авч үзэж болно. Жишээлбэл, Нефтийн бүтээгдэхүүний

буцлах температур гэх мэт үзүүлэлт нь ижил байдгаас нэг төрлийн бодис гэж үздэг. Ийм бодист нэг бодис гэж үзэн олон улсын бүртгэлийн дугаар (CAS буюу Chemicals Abstract Service) өгдөг байна.

4. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

НУБ-ын дугаар (UN number)-Олон улсын тээвэрлэлтэд ашиглах зорилгоор химийн хорт болон аюултай бодисыг дугаарласан 4 оронтой тоо. Ижил шинж чанартай бүлэг бодисыг нэг дугаараар дугаарласан байж болно.

Олон улсын бүртгэлийн дугаар (CAS number)-Химийн элемент, нэгдэл, полимер, микроорганизм, хольц болон хайлшийг Химийн асуудлаар тойм бэлтгэх албанаас (CAS) бүртгэж дугаарласан дугаар.

Озон задлах чадвар-Агаарын дээд мандлын озон давхаргыг задлах CFC-11-ийн чадвартай масс-массын харьцаагаар харьцуулсан тухайн галогент нүүрс устөрөгчийн озон задлах чадварын харьцангуй хэмжээ. CFC-11-ийн озон задлах чадварыг 1 гэж үзнэ. Жишээ нь, озон задлах чадвар нь 2 байна гэдэг нь CFC-11-ээс 2 дахин аюултай гэж ойлгоно.

5. ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН АНГИЛАЛ

5.2. Хортой бодис

5.2.12. Озоны давхаргад хортой бодис

Озон задлах чадвар гэж CFC-11-ийн агаарын дээд мандлын озон давхаргыг задлах чадвартай масс-массын харьцаагаар харьцуулсан тухайн галогент нүүрс устөрөгчийн озон задлах чадварын харьцангуй хэмжээ. CFC-11-ийн озон задлах чадварыг 1 гэж үзнэ. Жишээ нь,

озон задлах чадвар нь 2 байна гэдэг нь CFC-11-ээс 2 дахин аюултай гэж ойлгоно.

Озон задалдаг бодисууд нь Озоны үе давхаргыг задладаг бодисын тухай Монреалын протоколын хавсралтад орсон ба түүнд гишүүн орнууд нь нэмэлт, өөрчлөлт оруулдаг.

Озоны давхаргад хортой бодисыг 1 зэрэглэлээр ангилна.

Зэрэглэл	Шалгуур үзүүлэлт
Зэрэглэл 1	<ul style="list-style-type: none">• Монреалийн протоколын хавсралтад орсон бүх бодис• Монреалийн протоколын хавсралтад орсон хамгийн багадаа 1 бодисыг $\geq 0,1\%$ -аас их хэмжээгээр агуулсан бүх хольц

Аюулын талаарх мэдээлэл

Озоны давхаргад хортой бодисын шошгоны тэмдэг, тэмдэглэгээ

	Зэрэглэл 1
Анхааруулах тэмдэг	Анхаарлын тэмдэг
Дохио үг	Анхаар
Аюулын тэмдэглэгээ	Атмосферийн дээд давхаргын озоны давхаргыг задалснаар хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюул учруулна

6. ХОР АЮУЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

6.1. Хор аюулын лавлах мэдээлэл (ХАЛМ)

Ашиглагдаж байгаа болон хяналт тавих шаардлагатай байгаа химийн бодис, хольцын найрлага, шинж чанар, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хор аюул, нөлөө болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ХАЛМ-аас авна. ХАЛМ нь химийн бодистой харьцах аюулгүй ажиллагааны зааварчилгаа болон осол аюулын үед ажиллах төлөвлөгөө боловсруулахад ашиглах үндсэн эх сурвалж материал болдог.

Химийн хорт болон аюултай бодисын хор аюулын лавлах мэдээлэл (MSDS (ангилаар)) нь дараах мэдээллийг агуулсан байна.

1	Бодис, хольцын тодорхойлолт болон үйлдвэрлэгчийн талаарх мэдээлэл	<ul style="list-style-type: none"> - НС-ийн бүтээгдэхүүний тодорхойлолт - бусад тодорхойлолт - ашиглах заавар, хэрэглээний хязгаарлалт - үйлдвэрлэгч/нийлүүлэгчийн талаарх мэдээлэл (нэр, хаяг, утасны дугаар г.м) - аюул ослын үед холбогдох утасны дугаар
2	Хор аюулын тодорхойлолт	<ul style="list-style-type: none"> - Бодис, хольцын НС-ийн ангилал ба үндэсний болоод бүс нутгийн чанартай аливаа мэдээлэл - НС-ийн шошгоны тэмдэг, тэмдэглэгээ (Анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тэмдэглэгээ) - НС-ийн ангилалд ороогүй бусад аюул (жишээ нь, тоостой холбоотой үүсэх тэсрэлт г.м)

3	Найрлага/ бүрдэл хэсгийн талаарх мэдээлэл	<p><u>Бодис</u></p> <ul style="list-style-type: none"> - Химийн тодорхойлолт - Нэршил (химийн, техникийн болон олон улсын худалдааны нэр); - Олон улсын бүртгэлийн дугаар (CAS-ийн дугаар) - Бодисын ангилалд нөлөөлдөг, өөрөө ангилалд хамаардаг нэмэлт болон хольц <p><u>Хольц</u></p> <ul style="list-style-type: none"> - босго концентрациас их хэмжээгээр агуулагдаж байгаа НС-ийн хувьд аюултайд тооцогддог бүрдэл хэсгийн тодорхойлолт, концентраци болон концентрацийн хязгаар
4	Анхны тусламжийн арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> - бүх замаар өртөх үед авах шаардлагатай арга хэмжээ, тухайлбал, амьсгалах, арьс болон нүдээр хүрэлцэх, амаар уух г.м - химийн бодисоос үүсэх онцлог шинж тэмдэг - эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, шаардлагатай үед тусгай эмчилгээ хийх заалт
5	Гал унтраах арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> - тохиромжтой гал унтраах хэрэгсэл болон гал унтраахад ашиглаж болохгүй хэрэгсэл - галын аюулын үед химийн бодисоос үүсэх онцлог аюул (жишээ нь, галын аюулыг үед үүсэх шатамхай хий) - гал унтраах үед ашиглах хамгаалалтын хувцас хэрэгсэл, анхаарах зүйл

6	Химийн бодис алдагдах үед авах арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> - анхаарах зүйл, хувийн хамгаалалтын хэрэгсэл, осол аваарын үед ажиллах заавар - хүрээлэн буй орчны хувьд анхаарах зүйл - бохирдол тархахаас сэргийлэх болон цэвэрлэх арга хэмжээнд шаардагдах материал, аргачлал
7	Харьцах болон хадгалах	<ul style="list-style-type: none"> - химийн бодистой харьцахад анхаарах зүйл - аюулгүй хадгалах нөхцөл, хадгалахад тохиромжгүй нөхцөл, хамт байлгаж болохгүй бүх хүчин зүйлийг харгалзсан аюулгүй хадгалах нөхцөл
8	Өртөлтийг хянах/хувийн хамгаалалт	<ul style="list-style-type: none"> - Хянах үзүүлэлт, жишээ нь, ажлын байран дах зөвшөөрөгдөх дээд хэмжээ, биологийн хязгаар түвшин г.м -Техникийн хяналт - Хувийн хамгаалах хэрэгсэл, хувийн хамгаалалтын арга хэмжээ
9	Физик, химийн шинж чанар	<ul style="list-style-type: none"> - гадаад байдал (физик төлөв, өнгө г.м) - үнэр - үнэр мэдрэгдэх босго - рН - хайлах/хөлдөх температур - буцлах эхний температур, буцлах температурын хязгаар - дөл авалцах температур - ууршилтын зэрэг - шатамхай байдал (хатуу бодис, хий) - шатах дээд, доод хязгаар болон дэлбэрэх хязгаар - уурын даралт - уурын нягт - харьцангуй нягт - уусах чанар - хуваарилалтын коэффициент: n-октанол/ус - өөрөө шатах температур - задрах температур - зууралданги чанар

10	Тогтвортой байдал, урвалын идэвх	<ul style="list-style-type: none"> - урвалын идэвх - химийн тогтвортой байдал - аюултай урвал явагдах боломж - зайлсхийх нөхцөл (жишээ нь, статик цэнэг, цохилт, чичиргээ г.м) - хамт байлгахад тохиромжгүй материал -задралын үед үүсэх аюултай бүтээгдэхүүн
11	Хоруу чанарын мэдээлэл	<ul style="list-style-type: none"> - өртөх зам (амьсгалах, амаар уух, арьс, нүдэнд хүрэлцэх) - физик, химийн болон хоруу чанартай холбоотойгоор үүсэх шинж тэмдэг - шууд болон хожим илрэх үр дагавар, мөн түүнчлэн богино болон урт хугацааны өртөлтөөс үүсэх арга нөлөө - хоруу чанарын тоон хэмжээ
12	Экологийн мэдээлэл	<ul style="list-style-type: none"> - Эко хоруу чанар (усан болон хөрсний орчинд) - тогтвортой байдал, задрал - биохуримтлал үүсэх боломж - хөрсөн дэх шилжих хөдөлгөөн - бусад сөрөг үр дагавар
13	Устгах арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> - Хаягдлын хэлбэр, түүнтэй аюулгүй харьцах, устгах тухай мэдээлэл, устгах арга, бохирдсон савыг устгах арга

14	Тээвэрлэх	<ul style="list-style-type: none">- НҮБ-ын дугаар- тээвэрлэж болох тээвэрлэлтийн хэлбэрийн НҮБ-ын нэр- тээвэрлэлтийн үеийн аюулын ангилал- сав баглаа боодлын бүлэг- байгаль орчинд үзүүлэх аюул- тээвэрлэх хэмжээ- хэрэглэгчийн мэдэх ёстой бусад анхаарах зүйл
15	Хууль эрх зүйн мэдээлэл	<ul style="list-style-type: none">- тухайн бүтээгдэхүүнд хамаарах эрүүл мэнд, байгаль орчин, аюулгүй ажиллагааны талаарх дүрэм, журам
16	ХАЛМ-ийг боловсруулах, шинэчлэх талаарх мэдээллийг багтаасан бусад мэдээлэл	

7. АНГИЛАЛ БОЛОН ШОШГОЖУУЛАЛТЫН НЭГДСЭН ХҮСНЭГТ

Озоны давхаргад хортой бодис

Ангилал		Шошго				Аюулын тэмдэглэгээний код
Аюулын ангилал	Аюулын зэрэг	Анхааруулах тэмдэг		Дохионы үг	Аюулын тэмдэглэгээ	
		Химийн бодисын ангилал хаягжуулалтын нэгдсэн систем	НҮБ-ын аюултай ачаа тээвэрлэх зөвлөмж (загвар журам)			
Озоны давхаргад хортой бодис	1		Анхааруулах тэмдэг шаардлагагүй	Анхаар	Атмосферийн дээд давхрагын озоны давхаргыг задалснаар хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюул учруулна	H420

Аюулын тэмдэглэгээний код

3. Байгаль орчинд хортой бодисын аюулын тэмдэглэгээ

Код	Аюултай бодисын аюулын тэмдэглэгээ	Ангилал	Зэрэглэл
(1)	(2)	(3)	(4)
H420	Атмосферийн дээд давхаргын озоны давхаргыг задалснаар хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюул учруулна	Озоны давхаргад хортой бодис	1

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 04 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар А/107

“ОЗОНЫ ҮЕ ДАВХАРГЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ВЕНИЙН КОНВЕНЦ”, “ОЗОНЫ ҮЕ ДАВХАРГЫГ ЗАДАЛДАГ БОДИСЫН ТУХАЙ МОНРЕАЛИЙН ПРОТОКОЛ”-ЫН НЭГДСЭН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

“Засгийн газрын тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын нэгдэн орсон “Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн Конвенц”, “Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн Протокол”-ын нэгдсэн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Конвенцийн хэрэгжилтийг бүрэн хангаж салбаруудын оролцоог нэмэгдүүлэх, тайлан мэдээг цаг хугацаанд нь хүргүүлж, идэвхтэй хамтын ажиллагаа явуулахыг Үндэсний зохицуулагч бөгөөд Конвенцийн нэгдсэн удирдах зөвлөлийн дарга Ц.Адъяасүрэнд даалгасугай.

САЙД

Н.БАТЦЭРЭГ

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын
2016 оны 04 дүгээр сарын12-ны өдрийн
А/107 дугаар тушаалын хавсралт

**“ҮЕ ДАВХАРГЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ВЕНИЙН
КОНВЕНЦ”, “ОЗОНЫ ҮЕ ДАВХАРГЫГ ЗАДАЛДАГ
БОДИСЫН ТУХАЙ МОНРЕАЛИЙН ПРОТОКОЛ”-ЫН
НЭГДСЭН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга	Ц.Адъяасүрэн	Озоны үндэсний албаны захирал
Нарийн бичгийн дарга	Д.Дуламсүрэн	Озоны үндэсний албаны ахлах мэргэжилтэн
	Ц.Мөнхбат	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны, Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын мэргэжилтэн
	Х.Майцэцэг	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Ж.Батбаяр	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Цаг уур, орчны шинжилгээний газрын Орчны шинжилгээний хэлтсийн дарга
	Н Гэрэлт-Од	Эрүүл мэнд, спортын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Эрүүл мэндийн техник, технологийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
	А.Энхжаргал	Эрүүл мэнд, спортын яамны харьяа Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн Орчны эрүүл мэнд, хор судлалын төвийн дарга
	Ж.Гэрэл	Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын газрын мэргэжилтэн
	Р.Сарантуяа	Онцгой байдлын ерөнхий газрын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн

Э.Одмөнх	Гадаад харилцааны яамны Олон талт хамтын ажиллагааны газрын байгаль орчны асуудал хариуцсан ажилтан
Б.Оюунбилэг	Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын Макро эдийн засгийн статистикийн газрын статистикч
С.Соронзонболд	Стандарчлал хэмжил зүйн газрын Мэргэжлийн боловсролын стандарчлалын дэд хорооны нарийн бичгийн дарга
Б.Мөнхбаяр	Гааль, татварын ерөнхий газрын Гаалийнхяналт, бүрдүүлэлтийн газрын улсын байцаагч
У.Өлзийцэцэг	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчин, аялал жуулчлал, геологи уул уурхайн хяналтын хэлтсийн улсын байцаагч
Н.Энхтайван	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хил, хорио цээрийн хяналтын газрын Химийн хорт болон аюултай бодисын хяналт хариуцсан стандарт, чанарын хяналтын улсын ахлах байцаагч
Д.Оюунгэрэл	Хүнс, хөдөө аж ахуйн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
А.Энхтүвшин	Барилга, хот байгуулалтын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн
П.Энхбаяр	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга
Л.Даваасүрэн	Монголын хөргөлт, халаалт, агаар сэлгэлтийн холбооны ерөнхийлөгч / тохиролцсоноор/
М.Улаанхүүхэн	Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны менежер /төхиролцсоноор/

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар А/349

ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэлийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Жагсаалтыг холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлд хүргүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Г.Нямдаваа/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү жагсаалтыг холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлд хүргүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Г.Нямдаваа/-д үүрэг болгосугай.

САЙД

Н.ЦЭРЭНБАТ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2017 оны 12 дугаар сарын 12 –ны өдрийн
А/349 дугаар тушаалын хавсралт

ЭХ ҮҮСВЭРЭЭС ГАРАХ ХОГ ХАЯГДЛЫН КОДЧИЛСОН ЖАГСААЛТ, ТЭДГЭЭРИЙН ЗЭРЭГЛЭЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хог хаягдлын тухай хуулийн 8.1.6 заалтыг үндэслэн эх үүсвэрээс гарах хог хаягдлын төрөл, шинж чанараар нь ангилалд хамааруулж, аюулын зэрэглэл тогтооход энэхүү жагсаалтыг ашиглана.

1.2. Энэхүү жагсаалтын зорилго нь хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох байгаль орчинд ээлтэй тогтолцоо бий болгох болон хаягдлын үйлчилгээний хураамж тогтоох, мэдээ мэдээлэл гаргахад ашиглахад оршино.

Гурав. Хог хаягдлын аюулын зэрэглэл

3.1. Хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх аюулын шинж чанараар нь “аюултай”, “хяналттай” болон “энгийн” гэж зэрэглэнэ.

3.2. Хог хаягдал нь 1 дүгээр хүснэгтэд заасан аюулын шинж чанараас нэг болон хэд хэдэн шинж чанарыг зэрэг агуулж байвал аюултай хог хаягдал гэж үзнэ.

Аюулын шинж чанар

НҮБ-ын ангилал	Аюулын код	Шинж чанар	Тайлбар
9	H12	Байгаль орчинд хортой	Биотод хортой нөлөө үзүүлэх, био хуримтлал үүсгэх замаар хүрээлэн буй орчинд түргэн болон урт хугацааны нөлөөлөл үзүүлдэг бодис, хаягдал

3.3. Аюултай хог хаягдлыг “А” гэсэн тэмдэглэгээгээр тэмдэглэх бөгөөд ийм тэмдэглэгээтэй хог хаягдлыг шууд аюултай хог хаягдал гэж үзнэ.

3.4. “Хяналттай” хог хаягдлыг “Х” гэсэн тэмдэглэгээгээр тэмдэглэх бөгөөд ийм хог хаягдал нь 2 дугаар хүснэгтэд заасан аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг 3 дугаар хүснэгтэд заасан босго түвшинтэй тэнцүү болон түүнээс их хэмжээгээр агуулж байвал “аюултай” хог хаягдал гэж үзнэ.

3.5. “Хяналттай” хог хаягдал нь аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг босго түвшингээс бага хэмжээгээр агуулж байвал “энгийн” хог хаягдал гэж үзнэ.

3 дугаар хүснэгт

Аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүний босго түвшин

Химийн хорт болон аюултай бодис	Босго түвшин
Хортой бодис (зэрэглэл 1,2), %	≥ 0,1
Хортой бодис (зэрэглэл 3,4), %	≥3.0
Хортой бодис (зэрэглэл 5), %	≥25.0

3.6.3 дугаар хүснэгтэд заасан аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг зэрэглэлд хамааруулахад химийн хорт болон аюултай бодисын ангиллыг мөрдөнө.

3.7. “Аюултай” болон “Хяналттай” хог хаягдлын код нь “*” гэсэн тэмдэглэгээтэй байна.

Жишээ нь: 13 01 04* Тосны шүүлтүүр А 08 03 03* Хортой бодис агуулсан хэвлэлийн будагны хаягдал
Х

Дөрөв. Хог хаягдлын бүлэг

4.1. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын бүлэгт харгалзах кодыг 4 дүгээр хүснэгтэд зааснаар мөрдөнө.

4 дүгээр хүснэгт

Хог хаягдлын бүлгийн код

Бүлгийн код	Хог хаягдлын бүлэг
14	Органик уусгагч, хөргүүрийн шингэн болон хөөс/ аэрозолийн хаягдал (07, 08 ангиллын хаягдал хамаарахгүй)
16	Бусад хог хаягдал
20	Ахуйн хог хаягдал (түүнтэй найрлага, бүтцийн хувьд ижил үйлдвэр, үйлчилгээ, албан байгууллагын хог хаягдал)

Тав. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл

5.1. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын бүлэг, дэд бүлэг, төрөлд харгалзах код болон тэдгээрийн аюулын зэрэглэлийг 5 дугаар хүснэгтэд зааснаар мөрдөгдөнө.

5 дугаар хүснэгт

Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл

Бүлгийн код	Хог хаягдлын бүлэг	Дэд бүлгийн код	Хог хаягдлын дэд бүлэг	Хог хаягдлын төрлийн код	Хог хаягдлын төрөл	Аюулын зэрэглэл
14	Органик уусгагч, хөргүүрийн шингэн болон хөөс/аэрозолийн хаягдал (Е, Ж ангиллын хаягдал хамаарахгүй)	14 01	Органик уусгагч, хөргүүрийн шингэн болон хөөс/аэрозолийн хаягдал	14 01 01*	Хлорфторт нүүрстөрөгч, HCFC, HFC	A
				14 01 02*	Бусад галоген агуулсан уусгагч болон уусгагчийн холимог	A
				14 01 04*	Галогент уусгагч агуулсан лаг болон хатуу хаягдал	X
16	Бусад хог хаягдал	16 02	Цахилгаан болон цахим тоног төхөөрөмжийн хаягдал	16 02 03*	Хлор фторт нүүрстөрөгчид, HCFC, HFC агуулсан хаягдал тоног төхөөрөмж	A
20	Ахуйн хог хаягдал (түүнтэй найрлага, бүтцийн хувьд ижил үйлдвэр, үйлчилгээ, албан байгууллагын хог хаягдал)	20 01	Ангилж цуглуулсан хог хаягдал (15 01 -ээс бусад)	20 01 12*	Хлорфторт нүүрстөрөгчид агуулсан хаягдал тоног төхөөрөмж, хэрэгсэл	A

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 11 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар А/450

МАЯГТ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Агаарын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, Засгийн газрын 2018 оны 277 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох" журмын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмж импортлох тухайн жилийн тоо хэмжээний хуваарьт бүртгүүлэх маягтын загварыг нэгдүгээр, озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис агуулсан тоног төхөөрөмж импортлох, суурилуулсан, худалдсан тухай маягтын загварыг хоёрдугаар, аж ахуй нэгж, байгууллагын импортлох, худалдсан, тоног төхөөрөмж цэнэглэсэн болон үлдэгдэл озон задалдаг бодис болон бусад орлуулах бодисын тайлан гаргах маягтын загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Озон задалдаг бодис болон бусад орлуулах бодисын хэрэглээг үе шаттайгаар бууруулах, хязгаар тогтооход дээрх маягтын дагуу хяналт тавьж ажиллахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Г.Нямдаваа/, Озоны үндэсний алба [Ц.Адъяасүрэн/-нд тус тус үүрэг болгосугай. .

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2016 оны "Маягт батлах тухай" А/55 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Н. ЦЭРЭНБАТ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн
А/450 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ОЗОН ЗАДАЛДАГ БОДИС БОЛОН БУСАД ОРЛУУЛАХ
БОДИС, ТЭДГЭЭРИЙГ АГУУЛСАН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
ИМПОРТЛОХ ТУХАЙН ЖИЛИЙН ТОО ХЭМЖЭЭНИЙ
ХУВААРЬТ БҮРТГҮҮЛЭХ МАЯГТ**

1. Аж ахуйн нэгжийн нэр
2. Холбогдох хуний нэр
(утасны дугаар, э-шуудан)
3. Бүртгэгдсэн хаяг
4. Бизнес хаяг (дээрхээс өөр бол).....
5. Регистрийн дугаар
(Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний
хуулбараа хавсаргана уу)
6. Татвар төлөгчийн дугаар
7. Аж ахуйн нэгж урьд өмнө озон задалдаг бодис (CFC/ HCFC)
импортлогчоор Озоны үндэсний албанд бүртгэлтэй эсэх (тийм
/ үгүй)
8. Хэрэв тийм бол хэзээнээс
9. онд озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис
импортлох тоо хэмжээ

Д/д	Бодисын төрөл	Бодисын олон улсын стандарт тэмдэглэгээ	Олон улсын бүртгэлийн дугаар	Импортлох тоо хэмжээ, кг
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				
9				
10				

10. онд озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис агуулсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж импортлох тоо хэмжээ

Д/д	Тоног төхөөрөмжийн төрөл	Импортлох тоо хэмжээ, ширхэг
1	Агааржуулагч төхөөрөмж (иж бүрдэл)	
2	Үйлдвэрлэлийн агааржуулагч төхөөрөмж (иж бүрдэл)	
3	Ахуйн зориулалттай хөргөгч, хөлдөөгч	
4	Ахуйн зориулалтаас бусад худалдаа нийтийн хоолны зориулалттай хөргөх, хөлдөөх төхөөрөмж (хөргөх эсхүл хөлдөөх төхөөрөмжөөр тоноглогдсон тавцан, лангуу, шүүгээ, бусад тавилга)	
5	Ахуйн зориулалтаас бусад эмнэлэг, лабораторийн зориулалттай хөргөх, хөлдөөх төхөөрөмж	
6	Ахуйн зориулалтаас бусад хөргөх, хөлдөөх бүтээгдэ хүүн, тоног төхөөрөмж	

11. Аж ахуйн нэгжийн/импортлогчийн бусад үйл ажиллагааны тухай мэдээлэл

.....

12. Озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн жилийн борлуулалт (нотлох баримтаар хангана уу)

Би дээрхи нарийвчилсан мэдээлэл үнэн, зөв гэдгийг үүгээр баталж байна.

Он сар өдөр:

Овог нэр:

Албан тушаал:

..... (Гарын үсэг)

Тамга тэмдэг

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн
А/450 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**ОЗОН ЗАДАЛДАГ БОДИС БОЛОН БУСАД ОРЛУУЛАХ БОДИС АГУУЛСАН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
ИМПОРТОЛСОН, СУУРИЛУУЛСАН, ХУДАЛДСАН ТУХАЙ ТАЙЛАНГИЙН МАЯГТ**

Аж ахуйн нэгжийн нэр:
Хаяг, утасны дугаар:
Тайлангийн хамрагдах хугацаа:

Д/Д	Тоног төхөөрөмжийн төрөл	Импортолс он тоо хэмжээ*	Хаана суурилуулсан / худалдсан	Суурилуулсан /худалдсан тоо хэмжээ	Брэнд нэр, марк	Хүчин чадал	Цэнэглэсэн бодисын төрөл /хэмжээ кг-аар/	Үлдэгдэл, тоо хэмжээ
1	Агааржуулагч төхөөрөмж							
2	Үйлдвэрлэлийн агааржуулагч төхөөрөмж							
3	Ахуйн зориулалттай хөргөгч, хөлдөөгч							
4	Ахуйн зориулалтаас бусад худалдаа нийтийн хоолны зориулалттай хөргөх, хөлдөөх төхөөрөмж (хөргөх эсхүл хөлдөөх төхөөрөмжөөр тоноглогдсон тавцан, лангуу, шүүгээ, бусад тавилга)							
5	Ахуйн зориулалтаас бусад эмнэлэг, лабораторийн зориулалттай хөргөх, хөлдөөх төхөөрөмж							
6	Ахуйн зориулалтаас бусад хөргөх, хөлдөөх бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж							

*Тайланг баталгаажуулсан нотлох баримт

Он сар өдөр:

Тайлан мэдээ гаргасан хүний нэр:

Албан тушаал:

.....(Гарын үсэг)

Тамга, тэмдэг

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 11 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар А/452

ЭРХ ОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Агаарын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, Засгийн газрын 2018 оны 277 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нэгдүгээр гарын үсэг зурах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, хоёрдугаар гарын үсэг зурах эрхийг Озоны үндэсний албаны захирал Ц.Адъяасүрэн нарт тус тус олгосугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Г.Нямдаваа/-т даалгасугай.

САЙД

Н.ЦЭРЭНБАТ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2018 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар А-429/257

ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох байгууллагуудад мэдэгдэн, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Г.Нямдаваа/-д, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/-д тус тус үүрэг болгосугай.

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Н.ЦЭРЭНБАТ

САНГИЙН САЙД

Х.ХҮРЭЛБААТАР

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Сангийн сайдын хамтарсан
2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн
А-429/257 дугаар тушаалын хавсралт

**ҮҮСЭХ ХОГ ХАЯГДЛЫГ ҮЙЛДВЭРЛЭГЧ
БОЛОН ИМПОРТЛОГЧ ХАРИУЦАХ ЗАРИМ
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖАГСААЛТ**

Дараах үйл ажиллагаа эрхлэгч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах үйл ажиллагааг хариуцна. Үүнд:

6. Өндөр даралтат сав;
7. Химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодол;
11. Аюултай хог хаягдал.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 04 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 67 ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 70 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хасвралтаар баталсугай.

2. “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-эд туссан ажлыг жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг улсын төсөв, гадаад, дотоодын зээл тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/-д үүрэг болгосугай.

3. “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг жил бүр Сайдын зөвлөлд, 2 жил тутам Засгийн газарт танилцуулж байхыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Н.Нарантуяа/-т үүрэг болгосугай.

**БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД Х.БАДЕЛХАН**

Барилга, хот байгуулалтын сайд,
2019 оны 04 дугаар сарын 02-ны
67 тушаалын хавсралт

**ТӨРӨӨС БАРИЛГЫН САЛБАРЫН ТАЛААР
БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ /2019-2029/⁶**

№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
Зорилт 1. Салбарын бүтэц, тогтолцоог оновчтой тогтоох, хууль эрх зүйн орчин, норм нормативын баримт бичгийг боловсронгуй болгох замаар барилгын техникийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж салбарын хөгжлийг эрчимжүүлнэ.						
Үйл ажиллагааны чиглэл 1.5. Олон улсад нийтлэг мөрдөгддөг гэрээ, стандартуудыг хэрэглэх, нэвтрүүлэх замаар барилгын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах;						
1.5.5	Олон улсын гэрээ, конвенцоор хориглосон хязгаарласан бодис агуулсан барилгын материал, барилгын агааржуулалт, халаалт, хөргөлтийн системд ашиглах тоног төхөөрөмжийн ашиглалтыг хязгаарлана.	ААН-ийн бүртгэл, хариуцлага тооцох журам	Хүлэмжийн хийн ялгарал, барилгын хог хаягдлын хэмжээ буурна. /Озон задлах бодисын хэрэглээ хамаарна/	БХБЯ	БОАЖЯ, МХЕГ	2019-2025

6 Засгийн газрын 2019 оны 70 дугаар тогтоол, Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2008 оны 10 дугаар
сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 660

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

/Хураагдсан бараа, тээврийн хэрэгслийг борлуулах журам/

Гаалийн тухай хуулийн 298.3, Засгийн газрын 1995 оны 131 дүгээр тогтоолын 5.1, Улсын гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2008 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Хураагдсан бараа, тээврийн хэрэгслийг борлуулах журам”-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ тушаалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Дэд дарга бөгөөд Санхүү, эдийн засгийн газрын дарга /Н.Болд/, харьяа гаалийн газар, хороодын дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Улсын гаалийн ерөнхий газрын даргын 2006 оны 17 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тушаалыг 2009 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Д. ЦЭВЭЭНЖАВ

Гаалийн ерөнхий газрын даргын
2008 оны 660 дугаар тушаалын хавсралт

ХУРААГДСАН БАРАА, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ БОРЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хураагдсан болон улсын орлого болсон бараа, тээврийн хэрэгсэл /цаашид “бараа” гэх/-ийг худалдан борлуулахтай холбогдсон дүгнэлт гаргах, үнэлэх, шилжүүлэх, устгах харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Барааг борлуулах ажлыг Монгол улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Гаалийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэ журмын дагуу гаалийн байгууллага зохион байгуулна.

Гурав. Бараа шилжүүлэх

3.1. Харьяа гаалийн газар, хороод нь валют, үнэт цаас, үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрээр хийсэн эдлэл, түүх соёлын дурсгалт зүйлс, палеонтологийн зүйлс, химийн хорт бодис, буу сум, тэсэрч дэлбэрэх зүйлс, тусгай хэрэгсэл, ямааны ноолуур, суудлын автомашин, зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах Конвенци /CITES/ -ийн 1, 2 дугаар хавсралтад орсон ан амьтан, ургамлын гаралтай түүхий эд, тарваганы арьс, бугын ясан, цусан эвэр, чив засаа, сүүл, барагшуун, чага мөөг зэрэг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон хязгаарласан барааг Гаалийн удирдах төв байгууллагад шилжүүлнэ.

Дөрөв. Бараа худалдан борлуулах

4.8. Гаалийн байгууллага нь барааг мэргэжлийн байгууллагын дүгнэлт, үнэлгээ гарснаас хойш 45 хоногийн дотор борлуулсан байна.

Долоо. Бусад

7.1. Энэ журмын 3.1-д заасан нэр бүхий барааг хүлээн авах, үнэлгээ тогтоолгох, дүгнэлт гаргуулах, шилжүүлэх, устгах ажлыг Улсын гаалийн ерөнхий газрын асуудал хариуцсан нэгж зохион байгуулж, хяналт тавина.

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 12 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар А/300

ЖАГСААЛТЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 268¹ дүгээр зүйлийн 268¹.1.8, 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.4 дэх заалт, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн гаалийн байгууллагын Зөвлөлөөс “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн Жагсаалтад 2012, 2017 онуудад оруулсан 467 багц нэмэлт, өөрчлөлт, Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар зарим үндэсний кодод оруулсан 13 удаагийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системд үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт”-ыг хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Гаалийн ерөнхий газрын даргын 2011 оны 207 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гаалийн ерөнхий газрын дэд дарга /Ё.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА

Б.АСРАЛТ

Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны
А/300 дугаар тушаалын хавсралт

БАРААГ ТОДОРХОЙЛОХ, КОДЛОХ УЯЛДУУЛСАН СИСТЕМД ҮНДЭСЛЭСЭН ГАДААД ХУДАЛДААНЫ БАРААНЫ АНГИЛЛЫН ЖАГСААЛТ

29-Р БҮЛЭГ ОРГАНИК ХИМИЙН НЭГДЭЛ

Зүйл	Мөр	Үнд. код	Барааны бичиглэл	Хэм-жих нэгж	Описание товаров	Description of goods
			<p>I.- НҮҮРСУСТӨРӨГЧ, ТҮҮНИЙ ГАЛОГЕНЖУУЛСАН, СУЛЬФЖУУЛСАН, НИТРОЖУУЛСАН, НИТРОЗЖУУЛСАН УЛАМЖЛАЛ</p> <p>Хоёр буюу түүнээс дээш төрлийн галоген агуулсан цагираг бус нүүрсустөрөгчийн галогент уламжлал:</p>		<p>I.- УГЛЕВОДОРОДЫ И ИХ ГАЛОГЕНИРОВАННЫЕ; СУЛЬФИРОВАННЫЕ, НИТРОВАННЫЕ ИЛИ НИТРОЗИРОВАННЫЕ ПРОИЗВОДНЫЕ</p> <p>- Галогенированные производные ациклических углеводородов, содержащие два или более различных галогена:</p>	<p>I.- HYDROCARBONS AND THEIR HALOGENATED, SULPHONATED, NITRATED OR NITROSATED DERIVATIVES</p> <p>- Halogenated derivatives of acyclic hydrocarbons containing two or more different halogens:</p>
	2903.71	00	Хлордиформетан (HCFC-22)	кг	Хлордифторметаны	Chlorodifluoromethane
	2903.72	00	Трихлортрифторэтан (HCFC-123)	кг	Трихлортрифторэтаны	Dichlorotrifluoroethanes

2903.73	00	Дихлорфторэтан (HCFC-141/141b)	кг	Дихлорфторэтаны	Dichlorotetrafluoroethanes
2903.74	00	Хлордифторэтан (HCFC-142/142b)	кг	Хлордифторэтаны	Chlorodifluoroethanes
2903.75	00	Дихлорпентафторпропан (HCFC-225ca/225cb)	кг	Дихлорпентафторпропаны	Dichloropentafluoropropanes
